

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ



Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2019 · 10 сар | Дугаар 12

ГАРЧИГ

1 Технологийн хурдацтай өөрчлөлт иргэдийн санхүүгийн шийдвэр гаргалтад нөлөөлж байна

2–4 Иргэдийн санхүүгийн боловсрол ба санхүүгийн зах зээл

4–5 Монгол Улсын нийт насанд хүрсэн иргэдийн 41 хувь санхүүгийн боловсролтой байна

5–6 Зохицуулалтын мэдээ

8–9 Тайлбар ба зөвлөмж

10–12 Финтек ба рэгтек – дижитал санхүүгийн боловсрол

12–13 Иргэдийн даатгалын болон хөрөнгийн зах зээлийн оролцоо

14–15 Таны санхүүгийн боловсролд

16–17 Өргөн дуран

17–20 Хэрэглэгч

20–23 Зах зээлийн мэдээ

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.
- 976 51 261611
- press@frc.mn
- www.frc.gov.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

ТЕХНОЛОГИЙН ХУРДАЦТАЙ ӨӨРЧЛӨЛТ ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД НӨЛӨӨЛЖ БАЙНА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СУДАЛГАА, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА **Н.ХҮДЭРЧУЛУУН**

Сүүлийн үед санхүүгийн боловсрол, санхүүгийн мэдлэг гэсэн нэр томъёо их хэрэглэгдэх болсон тэгвэл санхүүгийн боловсрол гэж яг юуг ойлгох вэ? гэсэн асуултаас ярилцлагаа эхэлье.

Санхүүгийн боловсрол гэдгийг олон байгууллага, судлаачид янз бүрээр тодорхойлж тайлбарласан байдаг хэдий ч санхүүгийн боловсрол гэдэг нь ерөнхийдөө тухайн хүн санхүүгийн харилцаанд оролцоходоо өөрийн нөхцөл байдал, нөөц баялгийг бодитоор үнэлэн, нийгэм, эдийн засаг, зах зээлийн хүчин зүйлсийг ойлгож, зөв зүйтэй, үр ашигтай шийдвэр гаргах мэдлэг, чадварыг хэлэх юм.

Өөрөөр хэлбэл та өөрийн хэрэглээ, хөрөнгө оруулалтаа удирдаж чаддаг, гэнэтийн эрсдэл үүсэхэд санхүүгийн хувьд тодорхой хэмжээнд даах чадвартай, хуримтлал, хөрөнгө оруулалт хийх, эсхүл яаралтай санхүүгийн хэрэгцээгээ шийдвэрлэхдээ олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс өөрт хамгийн тохирсон үр ашигтайг нь сонгож чаддаг тэр чадварыг хэлж байгаа юм.

Хүний амьдрал аз жаргалтай, эрүүл зөв үргэлжлэхэд санхүүгийн асуудал бол хамгийн чухал асуудлуудын нэг байдаг. Санхүүгийн асуудлаас үүдэн гэр бүл салалт, эрүүл мэндийн эрсдэл, сэтгэл санааны дарамт болон сэтгэцийн өвчлөл зэрэг нийгмийн олон асуудал нь хүнийг гарч байдаг. Мөн санхүүгийн асуудал нь хүнийг хамгийн их стрессдүүлдэг хүчин зүйлсийн нэг бөгөөд бидний өөртөө итгэх итгэлд хүртэл нөлөөлдөг гэсэн сэтгэлзүйн судалгаанууд байдаг. Тийм ч учраас бидний өдөр тутмын амьдралд байнгын хэрэглэгддэг мөнгө, санхүүтэй холбоотой асуудлуудыг ойлгодог, мэддэг, зөв шийдвэр гаргахад суралцдаг байх нь иргэн бүрт байх шаардлагатай хамгийн энгийн чадвар юм.

Түүнчлэн санхүүгийн зах зээл, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар сайн ойлголттой байх нь ард иргэдэд үр ашигтай санхүүгийн шийдвэр гаргах, өөрийн нөөц баялгаа сайн удирдаж, амьдралын чанараа дээшлүүлэх цаашлаад санхүүгийн системийг жолоодох боломжийг олгож байдаг.

» Үргэлжлэл 7-р нүүрт

ДИЖИТАЛ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

Сүүлийн жилүүдэд технологийн дэвшил нь санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг түгээх онцгой суваг болж байгаа бөгөөд олон улс орнуудын санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх үндэсний стратегид технологийн дэвлийг ашиглан иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх аргуудыг дурдсан байдаг. Гэхдээ дижитал инновацийг зах зээлд ихэвчлэн старт-ап болон финтек компаниуд буюу санхүүгийн салбар дахь хувийн компаниуд боловсруулж, хөгжүүлдэг учраас дамжуулах санхүүгийн мэдээ, мэдээллийн хувьд хувийн ашиг сонирхлын шинжийг агуулсан байх сул талтай юм.

Технологийн ухаалаг шийдлүүдийг ашигласан дараах хэрэгслүүд нь санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх үр дүнтэй суваг болж байна. Үүнд:

- Санхүүгийн мэдээлэл, зөвлөгөө сургалтын хүртээмжийг сайжруулсан бүх төрлийн цахим хуудсууд болон нээлттэй онлайн сургалтууд;
- Иргэдийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, туршлагажуулах төрөл бүрийн тоглоомууд;
- Санхүүгийн менежмент, мөнгөний зарцуулалтыг сайжруулах гар утасны аппликэйшн болон төсвөө тооцох арга хэрэгслүүд;
- Хэрэглэгчдийн зан төлөвийг сайжруулах автомат сануулга, өөрийн үйлдлийг хянах зориулалттай аппликэйшн.

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.



ХӨГЖЛИЙН ГАРЦ



ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ БА САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
А.БАДАМСҮРЭН

2008 оны дэлхийн санхүүгийн хямрал нь 1929 оны Их Хямралаас хойшхи 70 гаруй жилийн хугацаанд дэлхийн эдийн засагт хамгийн хүчтэй цохилтыг үзүүлсэн шок байсан гэж ОУВС онцолжээ. Тус байгууллагаас 2019 оны 3 дугаар сард гаргасан судалгааны ажилд дэлхийн эдийн засгийн хямралын үе дууссанаас хойш 10 жил өнгөрсөн ч улс орнуудын засгийн газрын дундаж өрийн хэмжээ болон нийт ДНБ-ий харьцаа 51 хувь байгаа бөгөөд, хямралын өмнө 36 хувь байсан тухай дурджээ.

Эрсдэл өндөртэй, эргэн төлөлт хийгдэх эсэх нь тодорхой бус орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад их хэмжээгээр борлуулснаас үүдэж, АНУ-ын орон сууцны зах зээл дээр хөөс хагарснаар дэлхийн эдийн засгийн түүхэнд хэмжээлшгүй их гарз хохирол учруулсан дэлхийн санхүүгийн хямрал үүсэх гол үндэс тавигдсан байдаг. Санхүүгийн бүтээгдэхүүнийг буруу борлуулах нь хөгжингүй улс орнууд болон Азийн орнуудын эдийн засгийг хямралд хүргэхэд шууд нөлөө үзүүлсэн бөгөөд үүнийг эрдэмтэн, судлаачид нэг талаар зээлдэгч, хөрөнгө оруулагчдын санхүүгийн мэдлэг хангалтгүй байсантай холбон тайлбарлаж байна. Үүнтэй холбоотойгоор иргэдийн санхүүгийн боловсрол, санхүүгийн мэдлэгийг сайжруулах тал дээр улс орны бодлого боловсруулагчид ихээхэн анхаарал хандуулах болсон юм. Ийнхүү санхүүгийн боловсрол нь зах зээлийн тогтвортой үйл ажиллагаа, зохистой зохицуулалтын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон бөгөөд иргэдийн санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх нь улс орнуудын урт хугацааны

бодлогын тэргүүлэх чиглэл болсоор ирэв.

Их 20-ийн удирдагчид санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх бодлогын ач холбогдлыг нухацтай авч үзэн улс орнууд Санхүүгийн боловсролын үндэсний стратегийг боловсруулахдаа баримтлах зарчмуудыг 2012 онд баталсан юм. Үүнтэй холбоотойгоор 2015 оны эцсийн байдлаар тус зарчимд үндэслэж нийт 59 улс өөрсдийн үндэсний хэмжээний санхүүгийн боловсролын стратегийг боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байв.

Монгол улсын хувьд Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2015 оны 10 дугаар сард баталсан байдаг. Тус хөтөлбөр нь 2016–2021 оны хооронд 2016–2019 он, 2019–2021 хүртэл гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжиж дуусах юм. Тус хөтөлбөр нь иргэдийн хувийн санхүүгээ зохистой удирдах чадварыг дээшлүүлэх; иргэдийн санхүүгийн залилан мэхлэлтээс өөрийгөө хамгаалах чадвартай болгох; санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг байгаа нөөц бололцоог зөв, үр ашигтай зарцуулан явуулах; санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд оролцож байгаа байгууллага болон хувь хүмүүс үр дүнтэй хамтран ажиллах, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх гэсэн үндсэн зорилтуудтай. Хөтөлбөрийн хүрээнд Хорооны зүгээс 21 аймгийн засаг даргын тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэст орон нутаг дахь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад чиглэсэн олон талт үйл ажиллагааг

зохион байгуулах жишиг удирдамжийг боловсруулж, хүргүүлэх, мөн орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд аймаг, сумд дахь багш нарт зориулсан “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалтыг зохион байгуулах зэрэг холбогдох ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

2017 оны 10 дугаар сард Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд тус хөтөлбөрт хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүүгийн зах зээлийн талаарх иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилго зорилтууд багтсан байдаг.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос 2018–2021 он хүртэлх стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд уг стратегийн үндсэн зорилгуудын нэг нь олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэж байгаа юм. Тус зорилгын хүрээнд Хорооны зүгээс банкнаас бусад санхүүгийн 4 салбарын талаар нээлттэй өдөрлөг, форум зохион байгуулж олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. Мөн СЗХ-ны www.frc.mn цахим хуудсанд “Таны санхүүгийн боловсролд” цонхыг шинээр нээж мэдээ мэдээлэл оруулж, иргэдэд санхүүгийн мэдээ, мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлж байна.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас /OECD/ санхүүгийн боловсролыг “Санхүүгийн зөв зохистой шийдвэр гаргах болон санхүүгийн хувьд бие даасан байдлыг бий болгоход шаардагдах мэдлэг, чадвар, хандлага болон зан байдлын хослол” хэмээн тодорхойлсон байдаг.

Нийгмийн хүрээнд ашиглах боломжтой илүү боловсронгуй, нарийн төвөгтэй санхүүгийн бүтээгдэхүүнүүд зах зээлд нэвтрэхэд хэрэглэгчид санхүүгийн мэдлэгтэй байх нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, санхүүгийн байгууллагууд хүүгийн болон хугацааны илүү олон сонголттой хадгаламжийн болон хөрөнгө оруулалтын багцуудыг хэрэглэгчдэд борлуулснаар харилцагчдыг урьд өмнөхөөсөө илүү ахисан түвшний санхүүгийн мэдлэгтэй байхыг шаардаж байна. Ингэснээрээ санхүүгийн хэрэглэгчид өөрийн хэрэгцээ шаардлагад тохирсон зөв зохистой шийдвэрүүдийг гаргахад тустай юм.

Санхүүгийн мэдлэггүй байх нь илүү зардал гаргахад хүргэдэг талаар нэр бүхий эрдэмтэн судлаачид судалгааны ажилдаа дурджээ. Тухайлбал, нийлмэл хүүгийн талаар мэдлэг дутмаг харилцагчид гүйлгээний шимтгэлд илүү их мөнгө зарцуулах, өндөр хүүтэй зээл төлөх, их хэмжээний өр тавих зэрэг нь нийтлэг ажиглагддаг байна.¹ Харин санхүүгийн өндөр боловсролтой хүмүүс зарцуулалтаа төлөвлөх, мөнгө хадгалах, хувьцаанд хөрөнгө оруулах мөн илүүтэй хөрөнгө хуримтлуулах хандлагатай байдаг байна.² Мөн эдгээрээс гадна, санхүүгийн мэдлэг мэдээлэл муутай иргэд санхүүгийн залиланд өртөх магадлал өндөртэй байдаг. Хүмүүс амар хялбар аргаар их хэмжээний мөнгө олох гэсэн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн богино хугацаанд хөрөнгийг нь хэд дахин өсгөж өгөх амлалт бүхий санхүүгийн пирамид буюу сүлжээний бизнест өртөх тохиолдлын тоо жил бүр өсөн нэмэгдсээр байна. Тухайлбал, 2017 онд Бүгд найрамдах Казакстан улсын иргэн “Жи тайм” гэх пирамид хэлбэрийн бизнесийг Монгол улсад явуулж, олон мянган хүнийг элсүүлж, мөнгө угаах аргаар залилан хийсэн нь тогтоогдсон бөгөөд 12 мянга орчим иргэнд


22 тэрбум төгрөгийн хохирол учруулсан байдаг. Монгол улсын нутаг дэвсгэрт олон шатлалт санхүүгийн бизнесийг явуулахыг хуулиар хориглосон бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.4-т “Олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэж заасан байдаг.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ҮНЭЛЭХ НЬ

Стандарт энд Пүүрс компани улс орнуудын иргэдийн санхүүгийн боловсролыг үнэлэх үүднээс 140 гаруй орны 15-аас дээш насны 150,000 иргэдээс судалгаа авсан бөгөөд S&P Global FinLit Survey тайланг гаргасан байдаг. Судалгааг эрсдэлийг тараан байршуулах, инфляц, хүүгийн тооцоолол, нийлмэл хүү гэсэн 4 сэдвийн хүрээнд мэдлэгийг үнэлэх үүднээс асуулгын аргаар аван, үр дүнг тооцон гаргажээ.

Судалгааны ерөнхий үр дүнгээс харахад эдийн засаг нь өндөр хөгжсөн улс орнуудын иргэд өндөр санхүүгийн боловсролтой байх хандлага ажиглагджээ.

Зураг 1. ДНБ болон санхүүгийн боловсрол



Эх сурвалж: S&P Global FinLit Survey and Global Findex database.


Судалгааны үр дүнгээс харахад Австрали, Канад, Дани, Финлянд, Герман, Израиль, Нидерланд, Норвеги, Швед, Их Британи зэрэг улсуудын насанд хүрсэн иргэдийн 65 болон түүнээс дээш хувь нь санхүүгийн өндөр мэдлэгтэй байв. Харин нөгөө талд, өмнөд Азийн орнууд санхүүгийн боловсролын оноогоор хамгийн доогуур жагсаж байгаа бөгөөд насанд хүрсэн иргэдийн дөрөвний нэг ба үүнээс цөөн хэсэг нь санхүүгийн мэдлэгтэй байдаг гэсэн үр дүнтэй байв.

Хөгжсөн болон эрчимтэй хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын иргэдийн санхүүгийн боловсролын түвшин харилцан адилгүй байна. Тухайлбал, насанд хүрэгсдийн санхүүгийн боловсролын түвшин доорх зураглалд харуулсан хөгжсөн эдийн засагтай улс орнуудын хувьд дунджаар 55 хувь байгаа бол эрчимтэй хөгжиж буй орнуудын хувьд 28 хувь байна.

¹ Лусарди болон Туфано, 2015

² Лусарди болон Митчел, 2014.

Зураг 2. Улс орнуудын иргэдийн санхүүгийн боловсролын түвшний ялгаа /Санхүүгийн боловсролтой насанд хүрэгсдийн хувь/



Эх сурвалж: S&P Global FinLit Survey

Харин тус судалгаанаас харахад Монгол Улсын нийт насанд хүрсэн иргэдийн 41 хувь нь санхүүгийн боловсролтой байна гэсэн үр дүн гарсан бөгөөд энэ нь дэлхийн дундаж буюу 33 хувиас дээгүүр үзүүлэлт

юм. Манай улс судалгаанд оролцсон улс орнуудтай харьцуулахад санхүүгийн мэдлэгийнхээ түвшингээр 140 орноос 42 дугаарт жагсаж байна.

“МОНГОЛ УЛСЫН НИЙТ НАСАНД ХҮРСЭН ИРГЭДИЙН 41 ХУВЬ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛТОЙ БАЙНА. /S&P GLOBAL FINLIT SURVEY/”

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

OECD-ээс улс орны засгийн газруудад зориулан “Санхүүгийн боловсрол ба мэдлэгийг дээшлүүлэх зарчим ба сайн туршлага”-зөвлөмжийг боловсруулан гаргасан бөгөөд үүнд дараах зөвлөмжүүдийг багтаажээ. Үүнд:

- Засгийн газар болон бусад холбогдох байгууллагууд шударга, уялдаатай санхүүгийн боловсролыг дэмжих;
- Санхүүгийн боловсролын хичээлийг ерөнхий боловсролын сургуулиудад орох;
- Санхүүгийн боловсрол нь санхүүгийн байгууллагуудын сайн засаглалын нэгэн хэсэг байх;
- Санхүүгийн боловсролыг сурталчилгаа хэлбэрээр олгохоос салангид авч үзэх; санхүүгийн байгууллагуудын ажилтнуудад зориулсан ёс зүйн дүрмийг боловсруулах;

- Санхүүгийн байгууллагууд тэдгээрийн харилцагчид мэдээллийг уншиж, ойлгож байгаа эсэхийг шалгах, тэр дундаа урт хугацаат үүрэг, амлалт эсхүл санхүүгийн томоохон үр дагавартай санхүүгийн үйлчилгээтэй холбоотой тохиолдолд ойлгоход хэцүү, жижиг үсгээр хэвлэсэн баримт бичиг үйлдэхээс татгалзах;
- Санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрүүд амьдрал төлөвлөлтийн чухал хэрэгслүүд болох даатгал, тэтгэвэр, өр төлбөр болон энгийн хадгаламж зэргүүдэд төвлөрөх;
- Хөтөлбөрүүд аль болох хувь хүн, тодорхой нэгэн нийгмийн бүлэгт чиглэсэн, санхүүгийн чадавхыг дээшлүүлэх зорилготой байх;
- Ирээдүйн тэтгэвэр хүртэгчид одоогийн улсын болон хувийн тэтгэврийн

тогтолцооны санхүүгийн хүртээмжтэй байдлыг үнэлэх шаардлагатай талаар мэддэг байх;

- Үндэсний хэмжээний кампанит ажил, тодорхой цахим хуудас, үнэгүй мэдээлэл олгох, сэрэмжлүүлэх системээр дамжуулан санхүүгийн хэрэглэгчдэд өндөр эрсдэлтэй асуудлуудын талаар /санхүүгийн залилан/ мэдлэг мэдээлэл олгох.

Эдгээр зөвлөмжүүдийг төр, хувийн хэвшлийн болон сайн дурын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд хэрэгжүүлж ажиллах, өөрсдийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор Монгол Улсын иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ГАМШГИЙН ЭРСДЭЛ БА САНХҮҮ, ДААТГАЛЫН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн ОБЕГ–ын дарга Бригадын генерал Т.Бадралттай уулзаж харилцан мэдээлэл солилцож, хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

Уулзалтын үеэр, гамшгийн эрсдэлийн даатгалын эрх зүйн орчин ба зохицуулалт, бизнес загвар, технологид суурилсан даатгал, хүртээмжтэй бүтээгдэхүүн, санхүү, даатгалын салбарын хөгжил, хамтын ажиллагааны талаар ярилцаж Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцлаа.

Мөн гамшгийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос Хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөр (MEFIN, The Mutual Exchange Forum on Inclusive Insurance)–тэй хамтран Төр, хувийн хэвшлийн олон улсын зөвлөлдөх ээлжит VII дугаар уулзалтыг “Уур амьсгал өөрчлөлтийн эрсдэлийн даатгал” сэдвээр Улаанбаатар хотноо 2019 оны есдүгээр сарын 17–18–ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөв.



ИРГЭДЭД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАГЧ БАГШИЙГ БЭЛТГЭВ.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголбанк, БСШУСЯ–ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”–ийг хэрэгжүүлж, хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох “Сургагч багш бэлтгэх” сургалтыг нэг жилийн турш амжилттай зохион байгууллаа.

Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлж, тэдэнд өдөр тутмын амьдралд тохиолдох санхүү, мөнгөний асуудлаа зөв шийдвэрлэх чадвар эзэмшихэд нь системтэйгээр туслах багш нарыг сургаж, чадваржуулах зорилгоор 21 аймагт зохион байгуулсан сургалтын үр дүнд 221 сургагч багшийг бэлтгэх ажил амжилттай явагдав.

Ээлжит сургалт 2019 оны наймдугаар сарын 24–26–ны өдрүүдэд Завхан аймагт, есдүгээр сарын 10–12–ны өдрүүдэд Хөвсгөл аймагт зохион байгуулагдав. Сургалтыг удирдан явуулах бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хорооны баг ажиллаж байна. Мөн аймгуудын арилжааны банкны ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, даатгалын зуучлалын, тэр дундаа ипотекийн даатгалын зуучлалын талаар зөвлөгөө, мэдээлэл өглөө.



ХОРООНЫ ЭЭЛЖИТ 14–Р ХУРАЛДААН БОЛЛОО.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит 14–р хуралдаан 9 дүгээр сарын 11–ний өдөр болж 14 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Хуралдаанаар “Эм Ай Ди Эй Си” ХХК–д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Апекс капитал ҮЦК”–д гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, “Их агдир” ХХК–д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо. Зарим үнэт цаасны компанийн албан тушаалтныг томилох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрөл нэмж олгох, сэргээх шийдвэр гаргаж, нэг үнэт цаасны компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

Нэр бүхий хадгаламж зээлийн хоршоодын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгалаа.

ХОРОО, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

Санхүүгийн зохицуулах хороо Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)–тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II дугаар үе шатны төсөл”–ийн хүрээнд компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийх, бодлогын зөвлөгөө боловсруулах, зэрэглэл тогтоох байгууллагын тогтолцоог судлах, биржийн бус арилжааны эрх зүйн зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлох зэрэг ажлыг хийхээр тохиролцож, 2019 оны гуравдугаар сараас хэрэгжүүлж эхлээд байна.

Энэхүү төслийн хүрээнд есдүгээр сарын 17–20–ны өдрүүдэд Япон болон Бангладеш Улсын зэрэглэл тогтоох байгууллагын төлөөллүүд Зэрэглэл тогтоох байгууллагын бодлогын баримт бичиг, ёс зүйн хэм хэмжээ, зэрэглэл тогтоох загвар, салбарын харьцуулалт, зэрэглэл тогтоох онол арга зүйн талаарх сургалтыг хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтнүүдэд заалаа.

Мөн ЖАЙКА–аас компанийн бондын зах зээлийн чиглэлээр сонгогдсон зөвлөх баг 2019 оны есдүгээр сарын 10–20–ны өдрүүдэд ажиллаж компанийн бондын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг судлах, компанийн бондын зах зээлийн талаар санал солилцох зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзалт хийв.

СЗХ-НЫ ДАРГА, ДОКТОР С.ДАВААСҮРЭН ТЭРГҮҮТЭЙ АЖЛЫН ХЭСЭГ ДАРХАН-УУЛ АЙМАГТ АЖИЛЛАВ

Дархан-Уул аймагт “Санхүүгийн зах зээл” нээлттэй өдөрлөг болж орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, банк, үнэт цаас, ББСБ, ХЗХ, Даатгалын байгууллагууд болон иргэд оролцлоо. Өдөрлөгийг Санхүүгийн зохицуулах хороо, Дархан-Уул аймгийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулав.



Энэ үеэр орон нутагт санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл өгөх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор даатгал, банк бус санхүүгийн

байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны зах зээл болон мөнгө угаах, терроризмтэй тэмцэх, комплаенсын чиглэлээр ээлжит сургалт, хэлэлцүүлгийг хийв.

Мөн санхүүгийн зохицуулах хорооноос 2018 онд зөвшөөрөл авч, амжилттай хэрэгжүүлж буй “Минжпроперти” ХХК-ийн гаргасан “Парк Таун” бондын төслийн ажилтай танилцав.



Ажлын хэсэгт Хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэн, Даатгалын газрын дарга М.Өлзийбат, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн гүйцэтгэх захирал Ж.Байгалмаа нар ажиллав.



БАЙР СУУРЬ

ТЕХНОЛОГИЙН ХУРДАЦТАЙ ӨӨРЧЛӨЛТ ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД НӨЛӨӨЛЖ БАЙНА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СУДАЛГАА, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
Н.ХҮДЭРЧУЛУУН



» Эхлэл 1-р нүүрт

Санхүүгийн боловсролын ач холбогдол юу вэ? Ер нь иргэдийн санхүүгийн мэдлэг өндөр байх нь нийгэм, эдийн засгийн хөгжилд яагаад чухал байдаг вэ?

Мэдээж хүн өөрийн санхүүгийн нөөц бололцоогоо үр ашигтай зарцуулж, өөрт хамгийн тохирсон тулгарч болзошгүй эрсдэлээс хамгаалсан санхүүгийн шийдвэр гаргаж сурах нь тухайн хүний зардлыг бууруулах, мөн өөрийн хөгжил, дэвшил, амьдралын чанарыг сайжруулахад зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байдаг. Энэ нь эргээд тэгш бус байдлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих нөлөөтэй бөгөөд санхүүгийн боловсрол нь эдийн засгийн өсөлтийг дэмждэг болох нь олон эмпирик судалгааны үр дүнгээр батлагдсан байдаг.

Түүнчлэн эдийн засаг, зах зээл нь хүмүүс бидний өдөр тутмын үйл хөдлөл дээр суурилан ажилладаг учраас санхүү, эдийн засгийн талаар зохих түвшний мэдлэггүй, буруу, төөрөгдүүлсэн мэдээлэлд иргэд их автдаг байх нь зах зээлд гажуудал үүсгэх сөрөг үр дагавартай байдаг.

Мөн нийгэм, эдийн засаг өөрөө хувь хүн, өрх гэрүүдээс бүрдэж байгаа тул өрхүүдийн санхүүгийн чадавх сайн, шийдвэр гаргалт нь үр ашигтай байх нь улсын эдийн засагт бас нөлөөлж байдаг. Жишээлбэл манай улсад иргэд, өрхүүд маань эдийн засаг сайжрах үед хэрэглээгээ хэт их нэмэгдүүлэх, зээлийн бүтээгдэхүүнээр хэрэглээгээ санхүүжүүлэх хандлагатай байдаг. Гэтэл манай улс шиг төрөлжилт багатай эдийн засгийн хувьд орлогын савлагаа ихтэй байдаг бөгөөд эргээд эдийн засгийн өсөлт удааширч эхлэхэд иргэдэд зээлийн төлбөр их хэмжээгээр үлдсэн байх өндөр эрсдэл үүсдэг гэсэн үг юм.

Тэгвэл иргэдийн санхүүгийн мэдлэг бусад улс орнуудын түвшинд хэр байгаа вэ? Монгол улсын хувьд бусад улсуудтай харьцуулахад хэр түвшинд байна вэ?

Санхүүгийн боловсрол нь өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудад түгээмэл тохиолдож буй нийтлэг асуудал юм. Норвеги, Дани, Швед, Англи, Герман зэрэг Европын улсуудын санхүүгийн боловсролын түвшин хамгийн өндөрт тооцогддог бол Азийн улс орнуудаас Сингапур тэргүүлдэг. Харин “Стандарт энд Пүүрс” – ээс явуулсан түүвэр судалгааны үр дүнгээс харахад манай улсын иргэдийн санхүүгийн боловсролын түвшин Япон, Хонг Конг зэрэг улсуудтай ойролцоо түвшинд байна.

Хэдийгээр дэлхийн хэмжээнд хийгдсэн уг судалгааны үр дүнгээс харахад манай улсын иргэдийн санхүүгийн боловсролын түвшин бүс нутгийн хэмжээнд өндөр байгаа хэдий ч хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн талаарх мэдлэгийн түвшин хангалтгүй байгаа нь манайхаас улирал тутам явуулдаг “Санхүүгийн зах зээл дээрх хэрэглэгчийн итгэлийн судалгаа”-ны үр дүнгээс ажиглагддаг.

Санхүүгийн зохицуулах хороо нь хөндлөнгийн судалгааны байгууллагатай хамтран иргэдийн санхүүгийн зах зээл дэх оролцоо, зах зээлийн талаарх мэдлэг, хүлээлтийг тандах судалгааг 2016 оноос хойш гүйцэтгэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд иргэдийн зах зээлд итгэх итгэл, мэдлэгийн түвшин харьцангуй сайжирч байгааг энд онцолмоор байна.

Мөн сүүлийн жилүүдэд технологийн дэвшил санхүүгийн зах зээлд хурдацтай нэвтрэн зах зээлд олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр гарч ирж санхүүгийн үйлчилгээг иргэд амар хялбар, түргэн шуурхай авах боломжтой болсон нь иргэдийн санхүүгийн шийдвэр гаргалт, зарцуулалтад ихээр нөлөөлж байна. Мэдээжийн хэрэг зах зээлийн уг хөгжил нь санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдэд санхүүжилтийн асуудлаа түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг олгож буй ч зээлийн карт, цахим мөнгө, интернет болон мобайл зээл зэрэг үйлчилгээ нь эргээд иргэдийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх, хэрэглээгээ тэлэн санхүүгийн сахилга батаа алдах зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэхэд төрийн байгууллага, санхүүгийн салбарын бодлого гаргагчдын оролцоо юу вэ? СЗХ-ны хувьд санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлд ямар бодлого баримтлан хэрэгжүүлж байна вэ?

Мэдээж санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлд төрийн байгууллагууд, тэр дундаа санхүүгийн зах зээлийн бодлого гаргагчдын үүрэг оролцоо ихээхэн чухал. Мөн санхүүгийн боловсрол нь зах зээлийн хөгжилд ихээхэн чухал нөлөөтэй тул дан ганц төрийн байгууллагад найдаад үлдэх биш санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагууд, мэргэжилтнүүд маань ч мөн хэрэглэгчдийнхээ боловсролыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах, иргэд ч мөн адил санхүүгийн боловсролыг хүн бүрийн хувьд зайлшгүй чухал чадвар гэдгийг ухамсарлан өөрсдийн мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэхэд тогтмол анхаарч байх шаардлагатай юм.

Манай улсын хувьд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Боловсрол, соёл шинжлэх ухааны яам хамтран 2015 оноос хойш “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг батлан амжилттай хэрэгжүүлж байна.

Мөн өмнө дурдсанчлан Санхүүгийн зохицуулах хорооноос улирал тутам явуулж буй судалгааны үр дүнгээс харахад орон нутгийн иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролын түвшин харьцангуй бага байгаа нь харагддаг. Тийм ч учраас бид өнгөрсөн хугацаанд орон нийтийн иргэдийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлд нэлээдгүй ажлуудыг хийсэн бөгөөд орон нутаг дахь ерөнхий боловсролын сурагчид, иргэдэд зориулсан сургалт, хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулах орон нутагт ажиллах санхүүгийн боловсрол олгох сургагч багшийг бэлтгэх зэрэг ажлуудыг хийж байна.

Түүнчлэн “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө 2018–2021” зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлтийг хангах зохицуулалтын байгууллагуудын талаарх мэдээ, мэдээллийг тогтмол хүргэн нээлттэй өдөрлөг, форумуудыг зохион байгуулан ажиллаж байна. Энэ дашрамд

дурдахад Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд “Таны санхүүгийн боловсролд” нэртэй цонх ажиллаж байгаа бөгөөд та бүхэн уг хуудаснаас зах зээлийн мэдээ, мэдээлэл, сэтгүүл, товхимлууд болон иргэдэд санхүүгийн мэдлэг олгох зорилго бүхий контентуудтай танилцах бүрэн боломжтой юм шүү.

Мөн санхүүгийн боловсролоос гадна нэг чухал зүйл нь иргэд өөрсдийн санхүүгийн мэдлэгээ бодитоор үнэлж чаддаг байх чадвар юм. Учир нь санхүүгийн боловсрол, мэдлэг багатай иргэн өөрийн мэдлэгийг бодитоор үнэлсэн тохиолдолд аливаа шийдвэрийг гаргахдаа мэргэжлийн хүний зөвлөгөөг сонсох байдлаар ханддаг бол эсрэгээрээ өөрийн мэдлэгийг бодит байдлаас өндрөөр үнэлдэг хүнд санхүүгийн үр ашиггүй шийдвэр гаргах эрсдэл өндөр байх юм. Харамсалтай нь хүн амын дийлэнх хувь нь өөрсдийн мэдлэг, чадварыг өндрөөр үнэлэх хандлагатай байдаг байна. Тэгэхээр санхүүгийн зөв шийдвэр гаргалтад дан ганц санхүүгийн мэдлэгээс гадна мөн тухайн хүний шийдвэр гаргах хандлага, олон нийтэд нээлттэй хүрдэг мэдээ, мэдээллийн үнэн зөв байдал, санхүүгийн байгууллагуудын ажилтан, зөвлөхүүдийн гүйцэтгэх үүрэг маш чухал гэдгийг дурдахыг хүсэж байна.

Ярилцсанд баярлалаа.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

СФА ИНСТИТУТААС ГАРГАСАН ЁС ЗҮЙН КОД БОЛОН МЭРГЭШЛИЙН СТАНДАРТ

Итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээчийн институт (Цаашид “СФА институт” гэх) нь хөрөнгө оруулалтын менежментийн мэргэжилтнүүдийн үнэ цэнийг бий болгох, нийгэмд ихээхэн хувь нэмэр оруулдаг ёс зүй, зах зээл дэх шударга байдал, практикийн мэргэжлийн стандартыг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын менежментийн үндсэн салбартай хамтран ажилладаг институт юм. Хөрөнгө оруулалтын менежментийн мэргэжилтнүүд гэдэг нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явцад голчлон оролцдог хүмүүс юм – ерөнхийдөө багцын менежерүүд, санхүүгийн зөвлөхүүд, судалгааны шинжээчид болно.

СФА институтийн үнэт зүйлсийн гол үндэс суурь нь Ёс зүйн код болон Мэргэшлийн стандарт бөгөөд эдгээр нь нийгмийн ашиг тусын тулд ёс зүйн өндөр хэм хэмжээ, боловсрол, мэргэжлийн ур чадварыг бий болгосноор хөрөнгө оруулалтын мэргэжлийг олон улсад тэргүүлэх эрхэм зорилгод нэн чухал үүрэгтэй юм. Түүнчлэн ёс зүйн өндөр хэм хэмжээ нь санхүүгийн зах зээл болон хөрөнгө оруулалтын мэргэжил дэх олон нийтийн итгэх итгэлийг хадгалахад чухал билээ. Энэхүү код болон стандарт нь 1960 онд бий болсноос хойш СФА институтийн гишүүдийн шударга ёсыг бэхжүүлж, мөн дотоодын хууль, дүрэм журам, соёлын

ялгаа, ажлын чиг үүргээс үл хамааран хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүдийн ёс зүйн хэм хэмжээг жиших загвар болон ашиглагдаж ирсэн. СФА институтийн гишүүд (итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээчийн цолтнууд) болон СФА-ийн цол горилогчид энэхүү код болон стандартын заалтуудыг баримталж, сахиулах үүрэг хариуцлагатай байдаг.

Ёс зүйн кодын заалтууд:

1. Олон нийт, харилцагчид, ирээдүйн харилцагчид, ажил олгогчид, ажилтнууд, хамт олон болоод олон улсын хөрөнгийн зах зээлд оролцогчидтой ёс зүйтэй, хүндэтгэлтэй, шударга, ур чадвартай болон хичээнгүй байдлыг баримталж ажиллах;
2. Хөрөнгө оруулалтын мэргэшлийн шударга ёс болон харилцагчдын ашиг сонирхлыг өөрийн ашиг сонирхлоос дээгүүр тавих;
3. Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтын зөвлөмж боловсруулах, хөрөнгө оруулалт хийх болон бусад мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэхдээ үндэслэл бүхий баримт, материалаар хангаж, мөн бие даасан мэргэжлийн дүгнэлтийг гаргах;
4. Бусдыг мэргэжлийн болон ёс зүйтэй байхыг уриалах;
5. Олон нийтийн ашиг тусын тулд дэлхийн хөрөнгийн зах зээлийн шударга ёс, үр

өгөөжийг идэвхжүүлэх;

6. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж мөн бусад хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэхийг зорих.

Харин Мэргэшлийн стандарт нь 7 бүлэгтэй бөгөөд бүлэг бүр дараах зүйлүүдтэй байна. Үүнд.

I. МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР

- A. Хуулийн талаарх мэдлэг (Knowledge of law)
Гишүүд болон цол горилогчид мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах аливаа эрх бүхий засгийн газар, зохицуулах байгууллага, мэргэжлийн нийгэмлэгийн холбогдох хууль, дүрэм журмыг ойлгож, дагаж мөрдөх. Хэрэв хууль, дүрэм хоорондоо зөрчилдвөл илүү хатуу хууль, дүрэм журмыг дагаж мөрдөх. Гишүүд болон цол горилогчид хууль, дүрэм журмыг зөрчсөн үйлдлээс татгалзах, мөн санаатайгаар үйл хэрэгт оролцохгүй байх.
- B. Бие даасан байдал ба бодит чанар (Independence and Objectivity)
Гишүүд болон цол горилогчид мэргэжлийн үйл ажиллагаандаа бодит чанар болон бие даасан байдлыг баримтлахын тулд үндэслэл бүхий баримт болон шийдлийг ашиглах. Гишүүд болон цол горилогчид өөрсдийн болон бусдын бие даасан

байдал болон бодит чанарыг алдагдуулж болзошгүй бэлэг, шагнал, тэтгэмж санал болгох, шахах, хүлээн авах ёсгүй.

В. Ташаа мэдээлэл (Misrepresentation)

Гишүүд болон Цол горилогчид хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ, зөвлөмж, үйл ажиллагаа эсвэл мэргэжлийн бусад үйл ажиллагаатай холбоотой аливаа ташаа мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх ёсгүй.

Г. Буруу үйл (Misconduct)

Гишүүд болон цол горилогчид шударга бус байдал, залилан, мэхлэх явдалтай холбоотой мэргэжлийн үйл ажиллагаанд оролцох ёсгүй, эсхүл мэргэжлийн нэр хүнд, ур чадвар, шударга ёсонд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдэл үйлдэх ёсгүй.

II. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ШУДАРГА ЁС

А. Дотоод мэдээлэл ашиглах (Material nonpublic information)

Хөрөнгө оруулалтын үнэ цэнэд нөлөөлөхүйц дотоод мэдээлэл хадгалж буй гишүүд болон цол горилогчид тэдгээр мэдээллийг ашиглах болон бусдад ашиглуулахгүй байх.

Б. Зах зээлийг урвуулан ашиглах (Market manipulation)

Гишүүд болон цол горилогчид зах зээлд оролцогчдыг төөрөгдүүлэх зорилготойгоор үнэт цаасны үнийг гажуудуулах, арилжааны дүнг хиймлээр өсгөх үйл ажиллагаанд оролцохгүй байх.

III. ХАРИЛЦАГЧДАД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

А. Үнэнч, оновчтой, анхааралтай (Loyalty, Prudence and Care)

Гишүүд болон цол горилогчид харилцагчдаа үнэнч байх үүрэгтэй, мөн анхаарал сонор сэрэмжтэй байж, оновчтой дүгнэлтийг гаргадаг байх үүрэгтэй. Гишүүд болон цол горилогчид харилцагчдын ашиг тусын төлөө ажиллаж, ажил олгогчийн эрх ашгаас харилцагчдын эрх ашгийг дээгүүр тавих.

Б. Эрх тэгш хандах (Fair Dealing)

Гишүүд болон цол горилогчид хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтын зөвлөмж өгөх, хөрөнгө оруулалт хийх, болон мэргэжлийн бусад үйл ажиллагаа эрхлэхдээ бүх харилцагчдад эрх тэгш хандах.

В. Нийцэл (Suitability)

1. Гишүүд болон цол горилогчид харилцагчдад зөвлөх үйлчилгээ үзүүлж

байгаа тохиолдолд дараах зүйлс хамаарна.

а. Аливаа хөрөнгө оруулалтын зөвлөмж өгөх эсхүл хөрөнгө оруулалт хийхээс өмнө харилцагчийн болон ирээдүйн харилцагчийн хөрөнгө оруулалтын туршлага, эрсдэл ба өгөөжийн зорилтууд, мөн санхүүгийн бэрхшээлүүд зэргийн талаар судалж, тэдгээр мэдээллүүдийг тогтмол хянаж, шинэчилж байх шаардлагатай.

б. Хөрөнгө оруулалтын зөвлөмж өгөх эсхүл хөрөнгө оруулалт хийхээс өмнө аливаа хөрөнгө оруулалт нь харилцагчийн санхүүгийн байдал болон бичгээр үйлдсэн зорилт болон хязгаарлалтад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох.

в. Харилцагчийн нийт хөрөнгө оруулалтын багцад нэмэлтээр хийх хөрөнгө оруулалт нь нийцэж байгаа эсэхийг нягтлах.

2. Хэрэв гишүүд болон цол горилогчид тодорхой стратеги, хэв маягийн дагуу хөрөнгө оруулалтын багцыг удирдах үүрэг хүлээсэн тохиолдолд, зөвхөн хөрөнгө оруулалтын багцын хамаарах зорилт, хязгаарлалтын хүрээнд хөрөнгө оруулалт хийх зөвлөмж гаргах шаардлагатай.

Г. Гүйцэтгэлийг мэдээллэх (Performance Presentation)

Гишүүд болон цол горилогчид хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг харилцан мэдээлэхдээ үнэн зөв, бүрэн гүйцэд, эрх тэгш байгаа эсэхэд тусгайлан анхаарах.

Д. Нууцлалыг хадгалах (Preservation of Confidentiality)

Гишүүд болон цол горилогчид дараахаас бусад тохиолдолд өмнөх, одоогийн болон ирээдүйн харилцагчдын талаарх мэдээллийг нууцлах ёстой. Үүнд:

1. Харилцагч болон ирээдүйн харилцагчийн хууль бус үйл ажиллагаатай холбогдох мэдээлэл;
2. Хуулийн дагуу мэдээлэх шаардлагатай бол, эсхүл;
3. Харилцагч болон ирээдүйн харилцагч нь мэдээллийг задруулахыг зөвшөөрсөн.

IV. АЖИЛ ОЛГОГЧИД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

А. Үнэнч байдал (Loyalty)

Гишүүд болон цол горилогчид ажил эрхлэлттэй холбоотой асуудлаар зөвхөн ажил олгогчийн эрх ашгийн төлөө ажиллах ёстой бөгөөд өөрийн ур чадварын давуу талаа ашиглан ажил олгогчийг хохироох,

нууц мэдээлэл задлах, эсхүл ажил олгогчид хохирол учруулах ёсгүй.

Б. Нэмэлт нөхөн олговор олгох (Additional Compensation Arrangements)

Гишүүд болон цол горилогчид оролцогч талуудаас бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ажил олгогчтой ашиг сонирхлын зөрчил үүсгэх бэлэг, тэтгэмж, нөхөн олговор, төлбөрийг хүлээн авах ёсгүй.

В. Ахлагчийн үүрэг (Responsibilities of Supervisors)

Гишүүд болон цол горилогчид тэдний удирдлага дор эсхүл эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй ажилтан холбогдох хууль дүрэм, журам болоод Ёс зүйн код болон мэргэшлийн стандартад нийцэж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих ёстой.

V. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ЗӨВЛӨМЖ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

А. Хичээнгүй, үндэслэлтэй байх (Diligence and Reasonable Basis)

Гишүүд болон цол горилогчид:

1. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, хөрөнгө оруулалтын зөвлөмж гаргах болон хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ хийхдээ хичээнгүй, бие даасан, тодорхой байдлыг баримтлах.
2. Аливаа хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ, зөвлөмж болон шийдвэр гаргахдаа судалгаа шинжилгээ бүхий хангалттай үндэслэлтэй байх.

Б. Харилцагчид болон ирээдүйн харилцагчидтай харилцах (Communication with Clients and Prospective Clients)

Гишүүд болон цол горилогчид:

1. Хөрөнгө оруулалтын анализ хийх, үнэт цаас сонгох, хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэхэд хөрөнгө оруулалтын үйл явцын талаарх ерөнхий зарчим болон үндсэн форматын талаар харилцагчид болон ирээдүйн харилцагчиддаа ил болгох.
2. Харилцагчид болон ирээдүйн харилцагчиддаа хөрөнгө оруулалтын явцад учирч буй эрсдэл, хязгаарлалтуудын талаар мэдэгдэх.
3. Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ, зөвлөмж эсхүл хөрөнгө оруулалт хийхэд ямар хүчин зүйлүүд чухал үүрэг гүйцэтгэж байгааг тодорхойлоход үндэслэлтэй дүгнэлтийг гаргаж

мөн тэдгээр хүчин зүйлүүдийн талаар харилцагчид болон ирээдүйн харилцагчиддаа мэдэгдэж байх.

4. Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээг танилцуулахдаа баримт/факт болон санал бодлыг ялгах.

В. Мэдээ баримтыг хадгалах (Record Retention)

Гишүүд болон цол горилогчид хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ, зөвлөмж, хөрөнгө оруулалт болон ирээдүйн харилцагчидтай солилцсон хөрөнгө оруулалтын талаарх мэдээ мэдээллийг гэрчлэх мэдээллийн санг хөгжүүлж хадгалах.

VI. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

А. Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх (Disclosure of Conflicts)

Гишүүд болон цол горилогчид ажил

олгогч, харилцагчид болон ирээдүйн харилцагчдад хүлээх үүрэгт харшлах эсхүл бие даасан байдал болон бодит чанарт нөлөөлөх бүхий л зүйлсийг бүрэн, шударгаар ил тод болгох. Гишүүд болон цол горилогчид холбогдох мэдээллийг энгийн хэлээр, үр дүнтэй байдлаар хүргэх.

Б. Гүйлгээний дэс дараалал (Priority of Transactions)

Гишүүн эсхүл цол горилогч нь бенефициар өмчлөгч байгаа тохиолдолд харилцагчид болон ажил олгогчийн хөрөнгө оруулалтын гүйлгээ нь урьталж явагдана.

В. Хураамж (Referral Fees)

Гишүүн болон цол горилогчид бүтээгдэхүүн, үйлчилгээг бусдад санал болгосноор хүлээн авсан эсвэл төлсөн тэтгэмж, төлбөрийн талаар харилцагчид, ирээдүйн харилцагчид болон ажил олгогчид мэдүүлэх.

VII. ГИШҮҮД БОЛОН ЦОЛ ГОРИЛОГЧДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

А. Хөтөлбөрийн оролцогч байх (Conduct as Participants in CFA Institute Programs.)

Гишүүд болон цол горилогчид нь CFA институтийн нэр хүнд, шударга байдлыг алдагдуулах, хөтөлбөрийн бүрэн бүтэн байдал, хүчин төгөлдөр байдал, аюулгүй байдлыг алдагдуулах аливаа үйлдэл хийх ёсгүй.

Б. CFA институт, CFA цол, CFA хөтөлбөрийн талаарх лавлагаа (Reference to CFA Institute, the CFA Designation, and the CFA Program)

Гишүүд болон цол горилогчид нь CFA институтэд гишүүнээр элсэх, CFA цол эзэмших, эсвэл CFA хөтөлбөрт нэр дэвших зэрэгтэй холбоотой асуудалд утга агуулгын далд болон хэтрүүлгийн аргыг ашиглах ёсгүй.

ФИНТЕК БА РЭГТЕК

ДИЖИТАЛ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

Сүүлийн жилүүдэд технологийн дэвшил нь санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг түгээх онцгой суваг болж байгаа бөгөөд олон улс орон санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх үндэсний стратегидаа технологийн дэвшлийг ашиглан иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх аргуудыг дурдсан байдаг. Гэхдээ дижитал инновацийг зах зээлд ихэвчлэн старт-ап болон финтек компаниуд буюу санхүүгийн салбар дахь хувийн компаниуд боловсруулж, хөгжүүлдэг учраас дамжуулах санхүүгийн мэдээ, мэдээллийн хувьд хувийн ашиг сонирхлын шинжийг агуулсан байх сул талтай юм.

Технологийн ухаалаг шийдлүүдийг ашигласан дараах хэрэгслүүд нь санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх үр дүнтэй суваг болж байна. Үүнд:

- Санхүүгийн мэдээлэл, зөвлөгөө сургалтын хүртээмжийг сайжруулсан бүх төрлийн цахим хуудсууд болон нээлттэй онлайн сургалтууд;
- Иргэдийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, туршлагажуулах төрөл бүрийн тоглоомууд;
- Санхүүгийн менежмент, мөнгөний зарцуулалтыг сайжруулах гар утасны аппликэйшн болон төсвөө тооцох арга хэрэгслүүд;
- Хэрэглэгчдийн зан төлөвийг сайжруулах автомат сануулга, өөрийн үйлдлийг хянах зориулалттай аппликэйшн.

Мөн санхүүгийн зах зээлд технологийн дэвшил ихээр нэвтрэн зах зээлийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж буй өнөө үед шинээр гарж ирж буй дижитал санхүүгийн үйлчилгээ нь хэрэглэгчдийн санхүүгийн боловсрол, санхүүгийн сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж буйг үнэлэх нь бодлого боловсруулагчдын баримтлах ёстой чухал зорилт болж байна.

Яагаад дижитал санхүүгийн боловсрол хэрэгтэй вэ?

OECD буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага 2011 онд гаргасан зарчимдаа санхүүгийн боловсролыг дэлхий нийтийн санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах 10 баганын нэгээр тодорхойлсон байдаг. Мөн 2016 онд G20 буюу Их 20 орнуудын дээд хэмжээний уулзалтаар гаргасан Дижитал санхүүгийн хүртээмжийн зарчмуудын 6 дугаар зарчимд дижитал санхүүгийн боловсролыг сайжруулахыг чухалчилсан байна.

Дижитал орчин хэрэглэгчдийн зан төлөвийн хандлагад ихээр нөлөөлж байна: Зан төлөвийн эдийн засгийн нэгэн судалгааны (Kahneman, 2003) үр дүнд хүмүүс рационал биш үйл хөдлөлтэй бөгөөд мэдээллийг яаж хүлээж авч байгаа нь тэдний үйлдэлд хүчтэй нөлөөлдөг гэж гарсан байна. Сүүлийн жилүүдэд хэрэглэгчдийн үйл хөдлөлд дижитал орчин хүчтэй нөлөөлж байгаа бөгөөд хэрэглэгчид сэтгэл хөдлөлөөр буюу “ганц даралт”-аар худалдан авалт хийх, шинэ технологийн бүтээгдэхүүнийг яаж ашиглахаа мэдэхгүй хэрнээ худалдаж авах гэх мэт асуудлуудтай их тулгарч байна. Үүнээс гадна хүмүүсийн “өнөө маргаашаа” гэсэн хандлага, өөрийгөө удирдаж сурахад бэрхшээлтэй байгаа зэрэг нь байдлыг улам ярвигтай болгосоор байна. Amazon, eBay, Google зэрэг том онлайн худалдаа, арилжааны платформууд хэрэглэгчдийн уг хандлагад суурилан худалдан авалтыг нэмэгдүүлэх зар сурталчилгааны бодлого баримтлан ажиллаж байна.

Зарим дижитал санхүүгийн байгууллагууд хэрэглэгчийн уг хандлагад суурилан нөхцөл байдлыг овжиноор ашиглах замаар ашиг хонжоо олох тохиолдлууд гарсаар байна. Жишээ нь: Өдрийн зээлийн байгууллагууд санхүүгийн яаралтай хэрэгцээ бүхий оюутнууд эсвэл залуу, туршлагагүй эмзэг хэрэглэгчдэд хурдан бөгөөд хялбар боловч өндөр хүүтэй зээлийг олгон, өрийн дарамтад оруулж байгаа эрсдэл ажиглагдсан байна.

Шигтгээ 1: Дижитал худалдаа хэрэглэгчдэд аюултай юу?

Онлайн төлбөр тооцоо: Зарим улсад бараа, бүтээгдэхүүн онлайнгаар авахдаа төлбөрөө худалдан авалтаас хойш төлөх боломжийг олгодог дижитал санхүүгийн үйлчилгээ байдаг. Өөрөөр хэлбэл, төлбөрийг анхны худалдан авалтаас хэдэн 7 хоног, сарын дараа тооцооны хуудсаар дамжуулан хийх боломжтой гэсэн үг юм. Иймэрхүү төрлийн үйлчилгээ үзүүлэгчид ихэнх тохиолдолд ямар ч хүүгүйгээр төлбөрөө төлөх боломж олгодог ба орлогын эх үүсвэрээ хүмүүсийн төлбөрөө хоцроож төлөхөд дагалдах шимтгэлээс голчлон бүрдүүлдэг байна. Энэ төрлийн эрсдэлд өртөгчид нь ихэнх тохиолдолд худалдан авалтын дараа төлбөрөө төлж чадна гэж төсөөлж байсан ч тэр нь талаар болсон хүмүүс байдаг.

Судалгаагаар (Prele, D болон D. Simester, 2000) хүмүүс кредит болон дебит картаар тооцоо хийхдээ бэлэн мөнгөөр хийхээсээ илүү мөнгө үрэх хандлагатай байгаа нь ажиглагджээ. Үүнтэй яг ижилхнээр хэрэглэгчид цахимаар төлбөр тооцоо хийхдээ бэлэн мөнгөөр тооцоо хийснээс илүү үрэх магадлалтай ба ингэснээр хувийн хэрэглээгээ хянах, зохицуулахад илүү хэцүү нөхцөл байдалтай тулгардаг байна.

Дижитал хаяг үүсгэхтэй холбоотой гардаг эрсдэлүүд: Технологийн дэвшлийн хурдтай хөгжлөөс шалтгаалан бидний өдөр тутмын амьдрал улам бүр цахимжиж байгаа бөгөөд хэрэглэгчид дижитал орчинд цахим ул мөрөө үлдээж байгаа нь тэдэнд хувийн болон санхүүгийн мэдээллээ дата цуглуулагч платформуудад алдах эрсдэлийг үүсгэж байна. Улмаар хэрэглэгчдийн санхүүгийн үйлчилгээ болон дижитал технологийн талаарх мэдлэггүй байдал нь тэднийг онлайнгаар залилуулах, дансаа хакердуулах, хувийн чухал мэдээллээ алдах зэрэг олон аюулд хүргэдэг. Эдгээрээс сэргийлэхийн тулд хэрэглэгчид технологийн талаар анхан шатны мэдлэгтэй болох, цахим орчинд нэвтрэхдээ анхаарал болгоомжтой, хариуцлагатай хандах хэрэгтэй юм.

Шигтгээ 2: Хэрэглэгчдийн мэдээллийг ашиглах нь – ашиг тус ба сул тал

Дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд технологийн дэвшлийн ачаар хэрэглэгчдийн цахим орчин дахь мэдээллийг ашиглан түүний мөнгөний урсгалыг таних, зээлжих зэрэглэлийг тогтоох замаар тухайн хэрэглэгчид яг тохирсон санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгох боломжтой болсон. Жишээ нь: Санхүүгийн байгууллагууд харилцагчдынхаа гар утасны мэдээлэл (дуудлага, мессэж, цахим мөнгөний шилжүүлгийн мэдээлэл)–ийг ашиглан зээлжих зэрэглэлийг үнэлэн, барьцаа хөрөнгийн шаардлагагүйгээр зээлийн үйлчилгээ санал болгож байна. Яг үүнтэй зэрэгцэн хүний дижитал орчинд үлдээсэн бүх ул мөр (картын гүйлгээ, утаснаасаа холбогдсон байршил, онлайн систем дэх хайлтууд зэрэг) хадгалагдаж үлддэг ба энэ нь хувийн мэдээллийн нууцлалын томоохон асуудлуудыг үүсгэдэг.

Эдгээр мэдээллийн нууцлал болон аюулгүй байдлын асуудлуудаас гадна тухайн хэрэглэгчийн хувийн мэдээллийг ашиглан онлайн хаяг үүсгэдэг асуудал сүүлийн үед их тохиож байна. Энэхүү зохиомол хаягт үндэслэн зарим байгууллагууд хэрэглэгчдийг сегментлэн маркетингийн бодлогоо явуулдаг ба энэ асуудал нь цаашлаад бодит хэрэглэгчийг тодорхой санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах боломжгүй байдалд хүргэдэг. Жишээ нь: Их өгөгдлийн сан буруу тооцоолсон бол хэрэглэгч тодорхой зээлийн бүтээгдэхүүний хүртээмжээс хасагдаад зогсохгүй бусад төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэндийн системээс хасагдах тэр ч бүү хэл ажлын байрны санал зэргийг мэдэхгүй үлдэх эрсдэл үүсэж байна.



Санхүүгийн боловсролыг дижитал арга хэрэгслүүдээр түгээхүй

Технологийн шинэчлэлийн хурдацтай байдлын ачаар сая сая хүмүүс интернетийг ашиглан ямар ч сэдвийн талаар мэдлэгтэй болж, мэдээллийг олох боломжтой болсоор байна. Бусад салбаруудтай адил боловсролын салбар ч энэ давалгаанд өртөн, үндсэн суурь боловсролыг дижитал платформуудаар түгээх боломжтой болж байгаа юм. Хөгжиж буй улс орнуудад суралцагч бүрт тохирсон байдлаар Khan academy болон Doorways to Dreams зэрэг байгууллагууд санхүүгийн боловсролыг олгох сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Санхүүгийн төрийн, оролцогчдын үүрэг: Санхүүгийн боловсролыг хувийн болон нэмэгдүүлэхэд ашгийн бус

Ихэнх улс орнуудад санхүүгийн боловсролын стратегийн гол хэрэгжүүлэгч нь төрийн эрх мэдэл бүхий байгууллагууд байдаг боловч зарим тохиолдолд стратегийг хэрэгжүүлэхэд хувийн компаниуд болон ашгийн бус байгууллагуудын оролцоо шаардлагатай байдаг. OECD–ийн INFE буюу Санхүүгийн боловсролын олон улсын гарц судалгаагаар улс орнуудын төрийн эрх бүхий байгууллагууд санхүүгийн боловсролыг сайжруулах бодлогыг дижитал санхүүгийн арга хэрэгслүүдийг ашиглан хүргэх нь үр дүнтэй гэж үзсэн байна.

Санхүүгийн боловсролоор тэргүүлэгч улс орнууд дараах болон хувь хүний хэрэгцээ шаардлагад тохирсон сургалтын онлайн системийг түлхүү ашиглаж байна.

Үүнд:

- Австрали – Money Smart
- Бельги – Wikifin
- Бразил – Life & Money and Financial Citizenship
- Их Британи – Money Matters
- Португал – Everybody Counts.

Ашгийн бус байгууллагуудын оролцоо санхүүгийн боловсролд:

Small change. Улс орнуудын санхүүгийн боловсролыг сайжруулах асуудалд зөвхөн төрийн байгууллагууд дангаараа оролцохгүйгээр хувийн байгууллагуудыг (ихэвчлэн start–up болон финтек компаниуд) ч оролцуулдаг байна. Үүнээс гадна ашгийн төлөө бус байгууллагууд ч мөн адил санхүүгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаандаа дижитал арга хэрэгслийг ашигладгийн нэг жишээ нь United Way Ottawa ашгийн бус байгууллага юм. UWO нь Канадын арилжааны банк болон Канадын Санхүүгийн хэрэглэгчийн агентлагтай хамтран “Small Change” аппликэйшнийг зохиосон нь хүмүүсийг мөнгөө хуримтлуулахад уриалахын хажуугаар олон нийтийн санхүүгийн боловсролыг сайжруулах хөтөлбөрүүдэд санхүүжилт босгоход туслах боломжийг бүрдүүлж өгсөн байна. Аппликэйшний тусламжтайгаар

хэрэглэгчид санхүүгийн зорилго тавин, хадгаламжаа хянах боломжтой юм. Аппликэйшн дээрх өдрийн хоол эсвэл кофены зардлаа танасан зэрэг санхүүгийн эерэг үйлдлийг хийх үед хамтрагч байгууллагаас санхүүгийн хөтөлбөрийг дэмжих санд тодорхой хэмжээний хандив хуримтлагдаж, харин хэрэглэгч санхүүгийн боловсролыг дэмжсэн “оноо” авдаг байна.



БНХАУ-ын хөдөө орон нутагт дижитал санхүүгийн боловсролыг түгээх нь: Эмэгтэйчүүдийн банк буюу “The Banking on Women” нь Positive Planet ашгийн бус байгууллага болон Diageo хувийн байгууллагын хамтран хэрэгжүүлж буй 3 жилийн хугацаатай санхүүгийн боловсролыг дэмжих төсөл юм. Энэхүү төсөл нь бичил зээл авах сонирхолтой эмэгтэйчүүдийн хариуцлагыг өндөрсгөж, санхүүгийн зөв шийдвэрүүдийг гаргахыг дэмжих зорилготой ба зорилтот бүлэг нь Huimin бичил зээлийн компанийн эмэгтэй зээлдэгчид байна.

Positive Planet-ийн хувьд санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн контентоо танхимын сургалт болон сошиал медиа аппликэйшн гэсэн 2 сувгаар түгээдэг ба аль аль суваг нь Хятадын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн, хэрэглэгч төвтэй байдлаар хүрдэг байна.

Төслийн танхимын сургалт нь Positive Planet-ийн мэргэжилтнүүд Huimin-ий ажилчдыг сургаж, харин тэдгээр ажилчид нь эмэгтэй зээлдэгчдийг сургах буюу сургагчдыг сургах (Training of trainers) ToT

зарчмаар явагддаг. Сургалтын дараах үнэлгээгээр тус сургалт нь зарцуулах биш хадгалах хандлагыг 39 хувиар, дижитал санхүүгийн үйлчилгээний зөв ашиглалтыг 46 хувиар, төсвөө тооцох зөв арга барилыг 107 хувиар, сарын төсвөө гаргах хандлагыг 74 хувиар өсгөсөн зэрэг эерэг үр дүнгүүдийг үзүүлжээ.

Төслийн 2 дахь жилийн эхээр сургалтын үзүүлэх нөлөө, хамрах хүрээг ихэсгэх зорилгоор BoW хөтөлбөрт дижитал бүрэлдэхүүн оруулж эхэлсэн бөгөөд 21–40 насны харьцангуй залуу хэрэглэгчдэд зориулан дижитал платформыг ашиглаж эхэлсэн. Гар утасны мессежний үйлчилгээ зэрэг нийтлэг арга хэрэгсэл нь хэрэглэгчид утасны дугаараа солих үед үр дүнгүй болох эрсдэлтэй байсан учраас хөтөлбөрт WeChat-ийг ашиглахаар шийдсэн байна. BoW төсөлд WeChat-ийг ашиглах болсон гол хүчин зүйл нь мессеж болон контентийг хуваалцах хялбар байдлаас гадна дижитал хэтэвч зэрэг санхүүгийн хэд хэдэн үйлдлийг гүйцэтгэх боломжтой байсан нь давуу талыг олгож байв. Банкны картыг WeChat хаягтайгаа холбосноор бусад хэрэглэгчдэд мөнгө шилжүүлэх, тэднээс мөнгө нэхэмжлэх бололцоотой болсон нь Huimin-ий харилцагчдад хэрэглэхэд хялбар байдал болон хэрэглэх үедээ суралцах боломжийг олгосон байна.



СУДЛААЧИЙН ИНДЭР

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН СУДАЛГАА: ИРГЭДИЙН ДААТГАЛЫН БОЛОН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОО

2019 оны 2 дугаар улирлын судалгааны үр дүн

Санхүүгийн зохицуулах хороо нь Үндэсний судалгаа, зөвлөгөөний төвөөр “Санхүүгийн зах зээлийн хэрэглэгчийн итгэлийг тандах судалгаа”-г улирал тутам гүйцэтгүүлдэг билээ. Энэхүү судалгааны зорилго нь иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоо болон санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг судлахад чиглэсэн бөгөөд судалгаанд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 1000 орчим иргэдийг хамруулдаг.

Түүвэр судалгаанд иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоог даатгал, зээл болон хөрөнгийн зах зээлийн хүрээнд авч үзэн, голчлон үйлчлүүлдэг санхүүгийн байгууллага, бүтээгдэхүүн, болон иргэдийн санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд итгэх итгэлийг тандах асуултыг оруулдаг.

“Хүртээмжтэй санхүү сэтгүүл”-ийн энэ удаагийн дугаарт 2019 оны 2 дугаар улирлын байдлаар иргэдийн даатгал болон хөрөнгийн зах зээлийн оролцоо хэр түвшинд буйг товч танилцуулж байна.

Судалгааны аргачлал: Судалгаа нь Монгол Улсын хэмжээнд явагдаж, санамсаргүй түүврийн аргаар сонгосон иргэдээс асуулга авах замаар мэдээллийг цуглуулдаг бөгөөд судалгааны асуулга нийт 3 бүлэг

асуултаас бүрддэг.


2019 оны 2 дугаар улирлын судалгаанд нийт 1,011 иргэн хамрагдсан бөгөөд нийт оролцогчдын 42.1 хувь нь эрэгтэй, 60.8 хувь нь 35–аас дээш насны иргэд, 58.0 хувь нь техник мэргэжлийн болон түүнээс дээш боловсролтой, 51.4 хувь нь Улаанбаатар хотод оршин суудаг иргэд байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн амьжиргааны түвшинг амьдардаг сууцны төрөл болон өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого гэсэн хувьсагчдаар тодорхойлсон ба оролцогчдын 54.1 хувь нь гэр болон хашаа байшинд амьдардаг ба 70.0 хувь нь өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого 200,000 төгрөгөөс байдаг өрхүүд байна.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2019 оны 2 дугаар улирлын байдлаар нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 30.3 хувь нь сайн дурын ямар нэг даатгалтай байна. Энэ нь 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 9.6 пунктээр өссөн дүн юм. Нийт иргэдийн 64.9 хувь нь даатгалгүй гэсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.1 пунктээр буурсан байна.


Зураг 3. Иргэдийн даатгалд хамрагдалт



Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн боловсрол, орлого, сууцны нөхцөл болон хүйс зэргээс хамааран ялгаатай байна. Өндөр орлоготой, дээгүүр боловсролтой, орон сууцанд амьдардаг, эрэгтэй хүмүүс илүүтэй даатгалд хамрагддаг байна. Мөн түүнчлэн, боловсролын түвшин доогуур иргэд даатгалын талаар мэдэхгүй гэж илүүтэй хариулжээ. Тухайлбал, дээгүүр боловсролтой иргэдийн 3.1 хувь нь даатгалын талаар мэдэхгүй гэж хариулсан бол доогуур боловсролтой иргэдийн 6.6 хувь нь ийм хариулт өгчээ.

Өндөр боловсролтой иргэдийн 34.9 хувь нь даатгалд хамрагдсан байхад бага боловсролтой иргэдийн 24 хувь нь даатгалд хамрагдсан байна. Харин орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд 35.9 хувь нь даатгалтай байгаа нь гэр хороололд амьдардаг иргэдтэй харьцуулахад 10.4 пунктээр өндөр байна.

Зураг 4. Даатгалд хамрагдалтын түвшин, бүлгээр




Даатгалд хамрагдаагүй иргэдээс хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 47.3 хувь нь хэрэгцээ шаардлагагүй гэж хариулсан. Энэ нь 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 14.2 пунктээр өссөн байна. Харин даатгалын хураамж өндөр учраас хамрагдаагүй гэж 11.7 хувь хариулсан нь өмнөх оны мөн үеэс 5.4 пунктээр буурчээ. Даатгалд итгэдэггүй гэсэн хариулт 11.9 байгаа нь 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад хэвэндээ байна. Харин даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт өмнөх оны мөн үеэсээ нэлээд буурч 24.9 хувь болжээ.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн зах зээл бол санхүүгийн зах зээлийн нэг чухал салбар юм. Иймд энэхүү судалгааны хүрээнд хөрөнгийн зах зээлийн оролцооны талаар иргэдээс хэд хэдэн асуулгаар мэдээлэл авсан. Иргэдийн 17.2 хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэж хариулсан бол 82.6 хувь нь үгүй, 0.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Мөн 2018 оны 3-р улирлын судалгаагаар энэхүү асуултад 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулж байсан бол 2019

Зураг 5. Даатгалд хамрагддаггүй шалтгаан




оны 2-р улиралд энэ хариулт 0.2 хувь болж огцом буурчээ.

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн ердөө 5.7 хувь нь үнэт цаасны арилжаанд оролцож байжээ. Сонирхож байсан иргэдийн 23.6 хувь нь өмнө нь хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байсан бол 76.4 хувь нь оролцож байгаагүй байна. Эндээс үзэхэд иргэд үнэт цаасны арилжаанд оролцохыг сонирхож байсан ч оролцооны түвшин доогуур байна.

Боловсрол өндөр, орон сууцанд амьдардаг, өндөр орлоготой, эрэгтэй, хотод амьдардаг иргэдийн 20 гаруй хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан бол боловсрол бага, гэрт амьдардаг, орлого багатай, эмэгтэй, хөдөө амьдардаг иргэдийн 10 гаруй хувь нь сонирхож байжээ.

Зураг 6. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцох сонирхол



Хөрөнгийн биржийн арилжааг сонирхохгүй байгаа шалтгааныг асуухад 29.6 хувь нь арилжаанд хэрхэн оролцохоо мэдэхгүй, 70.0 хувь нь мэдээлэл байхгүй гэж хариулсан. Түүнчлэн, 12.2 хувь нь арилжаанд оролцох хөрөнгө, мөнгө байхгүй шалтгаанаар сонирхдоггүй байна.

ДҮГНЭЛТ

Санхүүгийн зах зээлийн оролцоог даатгал болон хөрөнгийн зах зээлийн хүрээнд авч үзэн санхүүгийн зах зээлийн оролцоо, оролцохгүй байгаа шалтгааныг тодорхойлсон.

Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн боловсрол, хүйс, орлого болон сууцны нөхцөл зэргээс хамааран ялгаатай байна. Өндөр орлоготой бөгөөд өндөр боловсролтой, орон сууцанд амьдардаг иргэд илүүтэй даатгалд хамрагддаг байна. Мөн түүнчлэн, боловсролын түвшин доогуур иргэд даатгалын талаар мэдэхгүй гэж илүүтэй хариулжээ.


Иргэдийн 17.2 хувь нь хөрөнгийн зах зээлд оролцохыг сонирхож байсан ч ердөө 5.7 хувь нь арилжаанд оролцож байжээ. Хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол бүлгүүдээр харилцан адилгүй байна. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцохгүй байгаа гол шалтгаан нь мэдээлэл байхгүй, хэрхэн оролцохоо мэдэхгүй гэж хариулсан.

ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД

УХААЛАГ ШИЙДВЭР ГАРГАЛТ

Дэлхийн хөгжингүй улс орнууд иргэдийнхээ санхүүгийн боловсролд анхаарал хандуулж хэрхэн өөрт байгаа эд хөрөнгөө ухаалгаар захиран зарцуулах, хэрэглэх, хуримтлах талаар мэдлэгийг багаас нь эхлэн санхүүгийн боловсрол олгох хичээлийн тусламжтайгаар дэс дараалалтайгаар эмх цэгцтэй олгох болжээ. Өмнө нь санхүүгээ хэрхэн зохицуулах нь тухайн хүний хувийн асуудал төдий ойлгож ирсэн бол өнөө үед санхүүгийн боловсролтой иргэд тухайн улсын эдийн засгийн хөдөлгөгч хүчнүүдийн нэг хэмээн ойлгох болжээ. Учир нь эдийн засгийн тогтвортой хурдацтай өсөлт нь санхүүгийн мэдлэг өндөртэй иргэдийн өдөр тутмын шийдвэр гаргалтуудын нийлбэрээр тодорхойлогддог. Санхүүгийн өдөр тутмын шийдвэр гаргалт гэдэгт өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдаж авах, машин, орон сууц худалдаж авах гэх мэт зарлагын талын шийдвэр гаргалтуудаас гадна ирээдүйн сайн сайхны төлөө өнөөдрөөс эхлэн хийж буй хуримтлал болон бусад төрлийн хөрөнгө оруулалт зэргийг багтаан ойлгож болно. Гэвч мэдээлэл, технологи хөгжихийн хэрээр тухайн хүн олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, олон нэр төрлийн үйлчилгээг хүссэн үедээ орон зай үл хамааран авах боломжтой болохын зэрэгцээ тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар ирээдүйд өгөх үр өгөөжийг сайн судалж таниагүйн улмаас зарим тохиолдолд алдагдал хүлээх, бусдад ашиглуулах, хэрэгцээгүй зүйлд хэт их хөрөнгө зарцуулах гэх мэт маш олон төрлийн асуудлуудтай тулгарах болсон. Хувь хүн санхүүгийн шийдвэр гаргахын өмнө дараах гурван зүйлсийг хувь хүний санхүүгийн мэдлэгт тулгуурлан сайтар бодон тунгаах хэрэгтэй байдаг.

Зураг 7. Санхүүгийн шийдвэр гаргахад анхаарах зүйлс



Тооцоотой байх: Хувь хүн өөрийн олж болох орлого, мөн гарч буй зарлагыг нарийн тооцож зарим нэг хэрэгцээгүй зардал байвал түүнийгээ багасгаж, нэмэлт орлого олох боломжтой санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ байгаа эсэхийг судалж байх хэрэгтэй. Санхүүгийн эрх чөлөөнд хүрэх нь энгийн зүйлсийг ч орхилгүй нарийн тооцоолохоос эхэлдэг.


Санхүүгийн нөөцийг бүрдүүлэх: Өөрийн анхан шатны хэрэгцээнд шаардлагатай мөнгөн хэмжээг тооцоолох цаашлаад орлогын тодорхой хувийг гарч болзошгүй эрсдэлд зарцуулах гэх мэтээр өөрийн санхүүгийн тогтмол нөөцийг бүрдүүлэх нь чухал юм. Санхүүгийн нөөц бүрдүүлэх нь таныг болзошгүй эрсдэлээс хамгаалахаас гадна ирээдүйн хэрэгцээндээ хөрөнгө оруулах боломжийг олгодог.

Төлөвлөгөөтэй байх: Санхүүгийн төлөвлөгөө нь хувь хүний ирээдүйн

хэрэгцээ, нөөц эх үүсвэрийн талаарх тодорхой бус байдлыг бууруулж, хувь хүний сэтгэл ханамж, хөрөнгө оруулалтаас хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгсэл болдог. Мөн төлөвлөгөөтэй байх нь хувь хүний санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээг шинжилж дүгнэсэн, ирээдүйн санхүүгийн аливаа үйл ажиллагааг чиглүүлэх луужин болж байдаг.

Түүнчлэн санхүүгийн шийдвэр гаргалтад амьдралын нөхцөл байдал, хувь хүний ертөнцийг харах өнцөг болон эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайн хүний амьдралын нөхцөл байдал, хувь хүний ертөнцийг харах өнцөг гэдэгт тухайн хүний нас, хүйс, орлого, өрхийн бүтэц, итгэл үнэмшил зэрэг хүчин зүйлүүд хамаарах бөгөөд эдгээр хүчин зүйлс нь тухайн хүний санхүүгийн шийдвэр гаргалтад шууд замаар нөлөөлдөг. Хувь хүний амьдралын нөхцөл байдал, ертөнцийг харах өнцгийг тухайн хүн зохицуулах, удирдах боломжтой бол эдийн засгийн хүчин зүйлсийг тухайн хүн удирдах боломжгүй боловч чухал хүчин зүйлсийг мэдсэнээр өөрийн орлогын хичнээн хувийг өнөөдөр хэрэглэх, хичнээн хувийг ирээдүйдээ зориулан хөрөнгө оруулалт, хуримтлал хийх зэрэг шийдвэр гаргалтыг хийдэг.

Зураг 8. Шийдвэр гаргалтад нөлөөлөх эдийн засгийн хүчин зүйлс



Мөн эдийн засгийн дараах хүчин зүйлс нь тухайн хүний санхүүг шууд нөлөөлөх боломжтой бөгөөд өчигдөр ашиггүй байсан хөрөнгө оруулалт өнөөдөр ашигтай байх нөхцөл байдлыг үүсгэдэг. Тиймээс дээрх хүчин зүйлс хэрхэн таны санхүүгийн шийдвэр гаргалт болоод санхүүд хэрхэн нөлөөлдөг болохыг авч үзье.

Инфляци: Хэрэглээний үнийг өсөлтийг илэрхийлдэг. Хэрвээ инфляци орлогоос тань хурдтай нэмэгдэх аваас таны худалдан авах чадвар буурах бөгөөд та нэмэлт орлого олох эсвэл хэрэглээгээ бууруулах шаардлагатай тулгардаг. Өөрөөр хэлбэл, өмнө нь таны орлого анхдагч хэрэгцээгээ хангаад тодорхой хувийг хуримтлал, хөрөнгө оруулалтад

зарцуулахад хүрэлцээтэй байсан бол инфляцийн түвшин нэмэгдэхийн хэрээр таны орлого өмнөх түвшинд зарцуулагдах боломжгүй болж хувирдаг. Тиймээс хувь хүн та санхүүгийн шийдвэр гаргахын өмнө хамгийн түрүүнд инфляцийн түвшин хэрхэн өөрчлөгддөг талаар судлах нь зүйтэй юм.

Хүүгийн хэмжээ: Таны хэрэглээний зардал, хуримтлал, хөрөнгө оруулалтад нөлөөлөх чухал хувьсагч бол зээлийн хүүгийн хэмжээ юм. Зээлийн хүүгийн хэмжээ нэмэгдэх нь хэрэглээний зээл болон бусад төрлийн зээлийн үйлчилгээний өртгийг нэмэгдүүлдэг бол нөгөө талаас хуримтлал, хөрөнгө оруулалтад хийсэн үр ашгийг нэмэгдүүлж байдаг.

Мөнгөний нийлүүлэлт: Эдийн засагт эргэлдэж буй мөнгөний хэмжээ нь бусад эдийн засгийн хүчин зүйлсэд нөлөөлөх замаар таны гаргасан аливаа шийдвэр гаргалтад нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, хэрвээ мөнгөний нийлүүлэлт нэмэгдвэл зээлийн хүү буурах бөгөөд энэ тохиолдолд таны хуримтлал болоод хөрөнгө оруулалтаас авах үр ашиг буурах магадлал өндөр юм.

Ажилгүйдэл: Ажилгүйдлийн түвшин буурах нь тухайн эдийн засаг өсөж байгаагийн дохио бөгөөд энэ эргээд таны санхүүгийн чадамж нэмэгдэх боломжтойг илэрхийлдэг. Ажилтай хүмүүсийн тоо нэмэгдэх нь хүн бүр өөрийн гэсэн тодорхой орлоготой болж буйг харуулах бөгөөд энэ нь танд хөрөнгөө нэмэгдүүлэх олон төрлийн боломж байгааг илтгэх юм.

Орон сууцны үнэ: Ажил эрхлэлт нэмэгдэх, хэрэглээний зардал өсөх, эдийн засаг сайжрах нь шинээр баригдах орон сууцны тоог нэмэгдүүлдэг. Хэрэв та ирээдүйд амьдрах орон сууц худалдаж авах мөн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулахаар шийдсэн бол орон сууцны нийлүүлэлт нэмэгдэх нь орон сууцны үнийг бууруулдаг. Энэ нь томоохон хэмжээний худалдан авалт хийх гэж буй бол сайтар тунгаах хэрэгтэй чухал үзүүлэлтүүдийн нэг юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Хувь хүн бүрийн санхүүгийн чадамж нэмэгдэх, худалдан авах чадвар сайжрахад хамгийн их нөлөөлдөг хувьсагч бол дотоодын нийт бүтээгдэхүүн буюу тухайн улс орны тухайн тайлант жилд боловсруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ юм. Тиймээс ДНБ-ий хэмжээ өсөж буй эсвэл буурч байгаагаас хамааран та хэрхэн өөрийн хөрөнгөө хуваарилах, захиран зарцуулах шийдвэрийг гаргах шаардлагатай болдог.

Худалдааны тэнцэл: Хэрэв худалдааны тэнцэл алдагдалтай гарах буюу импорт экспортоосоо их байвал валютын ханшаар дамжуулан үнэ өөрчлөгдөхөд хүрдэг. Өөрөөр хэлбэл, манай орны валютын ханш бусад орны валютын ханшийн эсрэг сулрах бөгөөд ингэснээр хэрэглэгчид илүү үнэтэй бараа бүтээгдэхүүн хэрэглэх шаардлага гардаг. Энэ нь тухайн иргэний өрхийн хэрэглээний зардалд өөрчлөлт оруулдаг.

Үнэт цаасны зах зээлийн индекс(Топ 20): Та өөрт байгаа хөрөнгөө урт хугацаанд хөрөнгө оруулах эсвэл богино хэмжээнд ашиг хийх зорилгоор захиран зарцуулах гэж байгаа бол хамгийн түрүүнд үнэт цаасны зах зээлийн индексийг харах нь зүйтэй юм. Учир нь үнэт цаасны зах зээлийн индекс нь зах зээлд бүртгэлтэй компаниудын хувьцааны үнийн өөрчлөлтийг харуулдаг. Хувьцааны үнийн өөрчлөлт нь таны оруулах гэж буй эсвэл нэгэнт оруулсан хөрөнгө оруулалт хэрхэн үр ашигтай байгааг харуулдаг чухал үзүүлэлт юм.

Эдийн засгийн хувьсах хүчин зүйлсийг бүрэн дүүрэн ойлгох нь санхүүгийн аль зах зээлд хөрөнгө оруулалт хийх, одоогийн болоод ирээдүйн хэрэгцээгээ хэрхэн зохицуулах, цаашлаад өөрт буй хөрөнгөө хэрхэн хуваарилах, оновчтой зарцуулах зэрэг маш олон төрлийн боломжийг олгодог. Санхүүгийн зах зээл нь өргөн хүрээг хамрах бөгөөд та хэдий хэмжээний санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг арвин байна төдий чинээ өөрийн хөрөнгөө учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломж нээгддэг. Санхүүгийн зах зээлийг зөвхөн хөрөнгийн зах зээл эсвэл банкны зах зээлээр төлүүлэн ойлгох нь дутмаг явдал тул санхүүгийн зах зээлийн бусад хэлбэрүүдийг сайтар судалж, аль болох эрсдэлгүй хөрөнгө оруулалт, хуримтлалыг бий болгох нь зүйтэй юм. Мэдээлэл технологи хөгжихийн хэрээр санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ тэдгээрийн тулгарч болзошгүй эрсдэл, авч болох үр ашгийн талаар цаг хугацаа, орон зай үл хамааран судалж өөрийн санхүүгийн бололцоонд тохирсон санхүүгийн үйлчилгээг авах боломж хүн бүрт адил олдож байгаа нь гайхалтай юм.

Зураг 9. Санхүүгийн зах зээлийн төрлүүд



Хувь хүн таны өдөр тутмын шийдвэр гаргалтууд нь эргээд таны ирээдүйн санхүүгийн нөхцөл байдалд нөлөөлж байдаг тул амьдралын нөхцөл байдал, өөрийн амьдралын хэв маягт тохирсон эдийн засгийн болзошгүй эрсдэлүүдийг сайтар тунгаан бодсоны үндсэн дээр өөрийн санхүүгийн шийдвэр гаргалтаа хийх нь нэн чухал юм. Дараагаар нь танд санхүүгийн ямар зах зээл илүү үр ашигтай байхаас нь хамааруулан өөрт байгаа хөрөнгөө захиран зарцуулах, хуваарлах хэрэгтэй.

ӨРГӨН ДУРАН

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЭЭЛЖИТ “ДЭЛХИЙН БОДЛОГЫН ЧУУЛГАН”-Д МОНГОЛ УЛС АМЖИЛТТАЙ ОРОЛЦОО.

Олон Улсын Санхүүгийн Хүртээмжийн Нийгэмлэг / СХН, The Alliance for Financial Inclusion, AFI/-ээс жил бүр зохион байгуулдаг Дэлхийн бодлогын ээлжит чуулган (Global Policy Forum) Бүгд Найрамдах Руанда Улсын нийслэл Кигали хотноо 9 дүгээр сарын 09–нөөс 13–ны өдрүүдэд болж дэлхийн 92 улсын 100 гаруй гишүүн байгууллагуын 800 гаруй оролцогчид хуран чуулсан юм.



Дэлхийн бодлогын 2019 оны чуулганыг “Технологиор дамжуулж эмэгтэйчүүд болон залуучуудын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд Дижитал санхүү, Ногоон санхүү, Санхүүгийн шинэ технологи (Финтек)–ийн шийдлүүд, тэдгээрийн зохицуулалтын технологи (Рэгтек) зэрэг санхүүгийн хүртээмжийн олон талт асуудлуудыг хэлэлцэж, гарцыг эрчимтэй эрэлхийлсэн нь үйл ажиллагааг улам үр нөлөөтэй болгосон юм..

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо нь 2009 онд тус нийгэмлэгт үндсэн гишүүнээр элссэн бөгөөд 2016 оноос “Хэрэглэгчийг чадавхжуулах, зах зээлийг зохицуулах”, “Дижитал санхүүгийн үйлчилгээ”, “Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдөл”, “Санхүүгийн хүртээмжийн стратеги”, “Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх”, “ЖДҮ–ийн санхүүжилт”, “Хүртээмжтэй ногоон санхүү” зэрэг нийгэмлэгийн бүх ажлын хэсэгт идэвхтэй ажиллаж ирсэн. Улмаар 2017 оны Дэлхийн бодлогын чуулганаар СЗХ–ны дарга, доктор С.Даваасүрэнг нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн гишүүнээр сонгосон нь санхүүгийн хүртээмжийн асуудлаарх аливаа үйл ажиллагаанд Хорооны манлайлах оролцоо, байр суурийг нэмэгдүүлснээр Монгол Улс тус нийгэмлэгт бодлого боловсруулах, удирдах болон бусад бүх түвшинд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлсэн билээ.

Уг чуулганы эхний өдөр бүс нутгийн хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах,



санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготойгоор байгуулагдсан Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санаачилгын зөвлөл /ЗЕТАБНСЗ, Eastern Europe & Central Asia Policy Initiative, ECAPI/-ийн ээлжит уулзалт болж өнгөрсөн бөгөөд уулзалтаар гишүүн орнуудын төлөөлөл дижитал санхүү, санхүүгийн шинэ технологийн тусламжтайгаар санхүүгийн хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх чиглэлээрх өөрсдийн сайн туршлагаасаа харилцан солилцож, ирэх жилийн ажлын төлөвлөгөөг хамтран хэлэлцсэн юм.

Түүнчлэн чуулганы хоёр дахь өдөр тус нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн 17 дахь ээлжит хуралдаан болон бүх ажлын хэсгийн хурал давхар эхэлсэн юм. Үүнд, Захирлуудын зөвлөл нь нийт есөн гишүүнтэй бөгөөд дэлхийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах стратеги, бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд гишүүн орнуудын оролцоог хангах, гүйцэтгэх удирдлага, зөвлөл хорооны гишүүдийг томилж, батлах, үнэлгээ өгөх болон олон улсын санхүүгийн хүртээмжийн талаарх бүхий л хамтын шийдвэрийг баталгаажуулах чиг үүрэгтэй.



Уг Захирлуудын зөвлөлийн ээлжит хурлаар СХН–ийн үйл ажиллагаа, зардал, санхүүжилтийн тайлан, “Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдөл”, “Дижитал санхүүгийн үйлчилгээ” ажлын хэсгүүдээс боловсруулсан “Хүртээмжийн тоон өгөгдлийн үндсэн бүрэлдэхүүн”, “Цахим мөнгөний бодлого” зэрэг баримт бичгүүд, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн оффисыг Европ тивд байгуулах болон удирдах зөвлөлийн удирдамж, төсөв, үйл ажиллагаатай холбоотой менежментийн асуудлуудыг хэлэлцсэн юм.

Түүнчлэн Захирлуудын зөвлөлийн хурлаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэхээр тогтсон бөгөөд Монгол Улсын гишүүнээр ажиллах 2 жилийн хугацаа энэ онд өндөрлөсөн боловч манай улсын оролцоо сайн, идэвх чармайлттай байгааг үндэслэн дахин 2019 онд улиран сонгогдсон баярт үйл явдал тохиосон билээ.

Кигалигийн Дэлхийн бодлогын чуулганы бүхий л үйл ажиллагааны үеэр Монгол Улсын оролцоо өндөр байгааг талууд илэрхийлж байсан юм. Ялангуяа санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд манай улсад харьцангуй дээгүүр, данс эзэмшилт зэрэг зарим үзүүлэлтээр хөгжилтэй орнуудын түвшинд явж буй болон жендерийн тэгш бус байдал огт байхгүй зэргийг талархан хүлээж авч байлаа.

Мөн СЗХ–ны дарга, доктор С.Даваасүрэн Дижитал платформ

ба финтекийн эко систем дэх зохицуулалтын боломжууд сэдэвт хэлэлцүүлгийг даргалсан нь Монгол Улсын хувьд шинэ хуудсыг нээсэн юм. Эцэст нь Дэлхийн санхүүгийн бодлогын чуулган амжилттай, мөнхүү ихээхэн ач холбогдолтой болж өндөрлөв. Энэ удаагийн чуулганд оролцсон Монгол Улсын СЗХ-ны оролцоо, түүний үр дүнг дээр дурдсан томоохон үйл ажиллагааны зэрэгцээ ажлын хэсгүүдийн хуралдаанууд, төр-хувийн хэвшлийн дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт, бүсийн санаачилгын зөвлөлийн хуралдаан гэх мэт олон үйл явдал, тэдгээрийн үр дүнгээр хэмжих учиртай.

“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ” ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨЛДӨХ VII УУЛЗАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Санхүүгийн зохицуулах хороо, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөр (MEFIN, The Mutual Exchange Forum on Inclusive Insurance)-тэй хамтран Төр, хувийн хэвшлийн олон улсын зөвлөлдөх ээлжит VII уулзалтыг Улаанбаатар хотноо 2019 оны 9 дүгээр сарын 17–18-ний өдрүүдэд зохион байгууллаа.




Зөвлөлдөх уулзалт нь уур амьсгал, гамшгийн эрсдэлийн даатгал (CRI)-ын эрх зүйн орчин ба зохицуулалт, түүний бизнес загвар, технологид суурилсан даатгалын салбар, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сэдвийн хүрээнд явагдсан ба уулзалтын үеэр

“Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөр (MEFIN)-ийн хуралдаан болсон бөгөөд уг хуралдааныг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн удирдаж явуулсан юм.



Түүнчлэн хурлын үеэр уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн даатгалын талаар нэгдмэл нэг ойлголттой байх тухай болон хууль эрх зүйн зохицуулалт, технологийн дэвшил, оролцогч бусад улс орнуудын туршлага, уур амьсгалын даатгалын бүтээгдэхүүнийг бий болгох гол зорилтот бүлэг, зорилтот түвшин зэрэг асуудлыг онцлон хэлэлцлээ.



ХЭРЭГЛЭГЧ

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1–д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж, 2019 оны 3 дугаар улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой нийт 69 өргөдөл, гомдол ирснээс 63 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 6 өргөдөл хянагдах шатанд байна. Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 1. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн утга

Д/д	Өргөдөл, гомдлын товч утга	2018/III тоо	Эзлэх хувь	2019/III тоо	Эзлэх хувь
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	24	30.4%	40	58.0%
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээлэл шалгуулах	22	27.8%	9	13.0%
3	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	2	2.5%	-	-
4	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	10	12.6%	10	-
5	Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй	1	1.2%	-	-
6	Лавлагаа гаргуулах	2	2.5%	-	-
7	Ногдол ашиг	4	5.0%	-	-
8	Хувьцаа эзэмшигчийн нэр зөрсөн	4	5.0%	-	-
9	Данс нээлгэх тухай	2	2.5%	-	-
10	Хувьцааг шилжүүлэх, шилжүүлэн авах	1	1.2%	-	-
11	Хөрөнгө оруулалтын сан	2	2.5%	4	5.8%
12	Бусад	4	6.3%	6	8.7%
	Нийт	78	100.0%	69	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дээрх өргөдлүүдийн 58.0 хувийг эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байгаа бөгөөд эдгээрийг өмнө нь Үнэт цаасны хороо /хуучнаар/-ноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон брокер, дилерийн компаниудаар дамжуулан арилжаалсан байна.

Хороонд үнэт цаасны зах зээлтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар урьдчилан шийдвэрлэв.

Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн утга	2018/III	2019/III
1	Хорооноос үүрэг, даалгавар хүргүүлсэн	6	15
2	Хууль, хяналтын байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэх	23	14
3	Албан бичгээр холбогдох хариуг өгч шийдвэрлэсэн	45	34
4	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	4	6
	Нийт	78	69

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТХТ” ХХК, үнэт цаасны компани болон шаардлагатай тохиолдолд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг байгууллагуудаас тайлбар, баримт материалыг гаргуулан авч тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэдэг. Харин хувьцааг зөвшөөрөлгүй арилжаалсан тохиолдол нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.10 дугаар зүйлийн 2.20 дахь хэсгийг зөрчсөн үйлдэлд хамаарах тул Зөрчил, шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд 34 иргэний өргөдөл, гомдлыг хянахад хувьцаа худалдах захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөлд нэр бүхий гарын үсэг зурагдсан тул тухайн гарын үсгийг хуурамч эсэхийг эрх бүхий байгууллагаар тогтоолгохыг албан бичгээр хариу өгсөн, мөн тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокерийн компаниар дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзээд 14 иргэний өргөдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлэв. Мөн нийт 15 иргэний өргөдлийн дагуу тэдгээрт учирсан хохирлыг барагдуулахаар 3 үнэт цаасны компанид үүрэг өгч, 5 иргэний үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь дансанд “Говь” ХК-ийн 5450, “Сор” ХК-ийн 28, “Махимпекс” ХК-ийн 12, “Дорнод” ХК-ийн 100, “АПУ” ХК-ийн 2900 ширхэг хувьцааг тус тус буцаан байршуулж, 2 иргэний хувьцаанд оногдох нийт 800.0 мянган төгрөгийн хохирлыг бүрэн барагдуулаад байна.

Даатгалын салбар

2019 оны 3 дугаар улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор өссөн дүнгээр нийт 135 өргөдөл ирснээс 123 өргөдөл хугацаандаа шийдвэрлэгдэж, 12 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна.

Хүснэгт 3. Даатгалтай холбоотой өргөдлийн товч утга

Д/д	Өргөдөл, гомдлын товч утга	2018/III тоо	Эзлэх хувь	2019/III тоо	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	78	75.8%	94	69.2%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	7	6.8%	7	5.1%
3	Нөхөн төлбөрийг хасаж олгосон	5	5.1%	16	12.5%
4	Хохирлын үнэлгээний талаар	3	3.1%	4	3.0%
5	Даатгалын хураамжийг илүү тооцсон	2	2.1%	0	0.0%
6	Бусад	7	7.1%	14	10.2%
	Нийт	103	100.0%	135	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өргөдөл, гомдлыг утгаар нь ангилбал, даатгагчийн зүгээс даатгалын нөхөн төлбөрийг олгохоос татгалзсан гэх өргөдлийн тоог өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 20.5 хувиар, нөхөн төлбөрийг дутуу олгосон тохиолдол 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилбал:

Хүснэгт 4. Даатгалын бүтээгдэхүүний төрөл

Д/д	Даатгалын төрөл	2018/III тоо	Эзлэх хувь	2019/III тоо	Эзлэх хувь
1	Жолоочийн хариуцлагын даатгал	13	12.6%	27	20.5%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	44	42.7%	56	41.1%
3	Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгал	21	20.4%	22	16.1%

4	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	4	3.9%	9	6.6%
5	Хөрөнгийн даатгал	4	3.9%	13	9.5%
6	Мал амьтны даатгал	3	2.9%	0	0.0%
7	Ачаа, тээврийн даатгал	2	1.9%	1	0.7%
8	Санхүүгийн даатгал	1	1.0%	0	0.0%
9	Зээлийн даатгал	1	1.0%	0	0.0%
10	Хуримтлалын даатгал	1	1.0%	0	0.0%
11	Хариуцлагын даатгал	1	1.0%	3	2.2%
12	Бусад	8	7.7%	4	2.9%
	Нийт	103	100.0%	135	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал жолоочийн хариуцлагын даатгал, орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгал, гэнэтийн осол, эмчилгээний, хариуцлагын болон хөрөнгийн даатгалын маргааны тоо өссөн үзүүлэлттэй бөгөөд эдгээр 6 даатгалын төрөлд хамаарах маргааны тоо нийт өргөдөл, гомдлын 97.0 хувийг эзэлжээ. Харин ачаа, тээврийн даатгалтай холбоотой маргаан буурсан байна.

Хүснэгт 5. Даатгалтай холбоотой өргөдлийн шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдолд хамааралтай даатгалын компани	Даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй	Даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлгүй	Шүүхэд хандах	Холбогдох хариу тайлбар, заавар, зөвлөгөө өгсөн	Шийдвэрлэх явцад нөхөн төлбөр олгогдсон
1	"Бодь даатгал" ХХК	2	7	3	-	-
2	"Мандал даатгал" ХХК	4	9	3	1	-
3	"Миг даатгал" ХХК	2	7	1	-	-
4	"Монгол даатгал" ХХК	6	2	1	-	-
5	"Номин даатгал" ХХК	-	-	4	1	1
6	"Соёмбо даатгал" ХХК	4	5	3	-	1
7	"Ард даатгал" ХХК	-	7	6	-	-
8	"Хаан даатгал" ХХК	3	2	1	-	1
9	"Практикал даатгал" ХХК	4	3	4	-	-
10	"Монре даатгал" ХХК	4	2	1	-	1
11	"Тэнгэр даатгал" ХХК	5	3	-	1	-
12	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	-	-	1	-	-
13	Бусад	-	-	-	7	-
	Нийт /123/	34	47	28	10	4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 6. Урьдчилан шийдвэрлэсэн даатгалын нөхөн төлбөрийн дүн

Д/д	Холбогдох даатгалын компани	Иргэн, хуулийн этгээд	Шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн дүн	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн
1	"Бодь даатгал" ХХК	6	43,867,067	39,807,000
2	"Мандал даатгал" ХК	2	63,915,556	3,165,000
3	"Миг даатгал" ХХК	3	71,981,515	3,574,100
4	"Соёмбо даатгал" ХХК	1	87,635,292	190,000
5	"Ард даатгал" ХК	4	79,744,272	40,782,500
6	"Хаан даатгал" ХХК	2	3,090,000	3,090,000
7	"Практикал даатгал" ХХК	1	48,614,366	7,552,000
8	"Монре даатгал" ХХК	2	13,329,482	13,329,482
9	"Тэнгэр даатгал" ХХК	1	56,632,427	388,000
	Нийт	22	468,809,977	111,878,082

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд чиглэлийн хэмжээнд даатгуулагч 22 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 468.8 сая төгрөгийг олгуулах урьдчилсан шийдвэрийг гаргаж, үүнээс нийт 9 иргэн, хуулийн этгээдэд нийт 111.9 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулаад байна.

Банк бус санхүүгийн байгууллага

2019 оны 3 дугаар улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 49 өргөдөл, гомдол ирснээс 42 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 7 өргөдөл хянагдаж байна.

Хүснэгт 7. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл

Д/д	Өргөдөл, гомдлын товч утга	2019/ III тоо	Эзлэх хувь
1	Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл	8	16.2%
2	Зээлийн гэрээний маргаан	5	10.2%
3	ББСБ-ын үйл ажиллагаа	22	44.9%
4	Лавлагаа болон зохицуулалтын бус	11	22.4%
5	Бусад /барьцааны зүйл/	3	6.2%
	Нийт	49	100.0 %

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацааны өргөдөл, гомдлын тоог 2018 оны мөн үетэй харьцуулбал, ББСБ-ын үйл ажиллагаа, зээлийн ангилал, лавлагаа авахтай холбоотойгоор ирүүлсэн өргөдлийн тоо өссөн бол зээлийн гэрээний маргааны тоо буурсан байна.

Хүснэгт 8. ББСБ-тай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн утга	2019/III
1	Хорооноос үүрэг даалгавар хүргүүлсэн	9
2	Хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх	5
3	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага оногдуулсан	1
4	Холбогдох хариу өгч шийдвэрлэсэн	38
5	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	6
	Нийт	49

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоо

2019 оны 3 дугаар улирлын байдлаар хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-ны үйл ажиллагаатай холбогдуулан нийт 6 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэжээ.

Хүснэгт 9. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдлийн товч утга

Д/д	Товч утга	2019/ III тоо	Эзлэх хувь
1	Лавлагаа гаргуулах	2	33.3%
2	Хадгаламж буцаан олгоогүй	-	-
3	ХЗХ-ны үйл ажиллагаа	4	66.7%
	Нийт	6	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 10. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн утга	2019/III
1	Хорооноос үүрэг даалгавар хүргүүлсэн	2
2	Хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх	-
3	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага оногдуулсан	-
4	Холбогдох хариу өгч шийдвэрлэсэн	4
5	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	-
	Нийт	6


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хувьцааны үнийн хэлбэлзэл: Хувьцааны үнийн хэлбэлзэл нь тухайн улс орны хувьцааны зах зээлийн тогтвортой байдлыг илтгэх гол үзүүлэлт юм. Монгол Улсын хувьцааны үнийн хэлбэлзлийг ТОП 20 индексээр төлөөлүүлж харуулав. 2018 оны 2 дугаар улиралд хувьцааны үнийн хэлбэлзэл 7.9 хувьтай байсан бол 2019 оны 2 дугаар улиралд 2.5 пунктээр буурч 5.4 хувьд хүрчээ. Хувьцааны үнэ хэт өндөр хэлбэлзэлтэй байх нь тухайн хувьцааны зах зээл өндөр эрсдэлтэй байгааг харуулдаг.


Зураг 10. Хувьцааны үнийн хэлбэлзэл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зах зээлийн өгөөжийн тархалтын хэлбийлт: Тухайн хувьцааны зах зээлийн өгөөжийн тархалт хэт зүүн тийш хэвийсэн байх нь цаашид их хэмжээний сөрөг өгөөжийг дагуулах магадлалтай байдаг бөгөөд зах зээлийн тогтворгүй байдлыг илэрхийлдэг. Монгол Улсын хувьд тус үзүүлэлтийг ТОП-20 индексийн өгөөжөөр төлөөлүүлсэн бөгөөд тархалтын тэгш хэмийн үзүүлэлт 2019 оны 2 дугаар улирлын байдлаар -0.5 байгаа ба энэ нь зах зээлийн хувьд сөрөг үзүүлэлт юм. 2012 оны 1 дүгээр улирлаас 2019 оны 2 дүгээр улирал хүртэлх ТОП 20 индексийн тархалтын тэгш хэмийн үзүүлэлт хамгийн ихдээ 1.3 байгаа бол хамгийн багадаа -1.6 байна.

Зураг 11. ТОП 20 индексийн өгөөжийг тархалтын тэгш хэмийн үзүүлэлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн эрсдэл: Харин зах зээлийн эрсдэлийн хувьд хүүгийн хэлбэлзэл, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс, валютын ханш гэх мэт макро хүчин зүйлс багтана. Монгол улсын даатгалын зах зээлийн хамгийн том тулгамдаж буй асуудал нь валютын ханштай холбогдох эрсдэл юм. Даатгалын компаниудын дийлэнхи нь давхар даатгалаа гадны даатгалын компанид хийлгэдэг бөгөөд сүүлийн гурван жилд дунджаар 40 гаруй тэрбум төгрөгийг гадаад валют хэлбэрээр шилжүүлсэн бөгөөд тайлант улиралд давхар даатгалын зардал даатгалын нийт хураамжийн орлогын 32.4 хувийг эзэлж байна. Даатгалын салбар өргөжихийн хэрээр тус салбар дахь гадаад валютын гадагшлах урсгал нэмэгдэж байгаа нь салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлал бий болгож байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч буй нь даатгалын компаниудад томоохон дарамт үүсгэх болсон.


Зураг 12. Давхар даатгалын хураамж, ам.долларын ханш /улирлын дүнгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк

Тайлант улиралд даатгалын компаниудын балансын хөрөнгийн 51.7 хувийг хөрөнгө оруулалтын дүн эзэлсэн ба үүний 55.9 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байгаа юм. Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2019 оны хоёрдугаар улиралд нийт 12.5 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон нь даатгалын орлогын¹ дүнгийн 29.9 хувийг эзэлжээ. Үүнийг задлан үзвэл ердийн даатгалын компаниудын хувьд хүүгийн орлого нь нийт даатгалын орлогын 24.8 хувь, урт хугацааны даатгалын компанийн 60.6 хувь, давхар даатгалын компанийн 66.9 хувийг бүрдүүлсэн байна. Эндээс дүгнэхэд урт хугацааны болон давхар даатгалын компанийн хувьд орлогын дийлэнх хувь нь хүүгийн түвшнээс, өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын хүүгийн орлогоос хамааралтай болох нь харагдаж байна. Манай улсын хувьд хүүгийн хэлбэлзэл харьцангуй тогтвортой байгаа тул энэ талын эрсдэл тулгамдах магадлал тун бага юм.

Зураг 13. Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Хөрөнгийн хүрэлцээт байдал: Хөрөнгийн хүрэлцээт байдлын үзүүлэлтийг тооцохдоо өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активд харьцуулах замаар тооцдог бөгөөд 2019 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд уг харьцаа 130.5 хувьтай байна.

Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа нь банк бус санхүүгийн байгууллагыг эрсдэлээс хамгаалах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг илэрхийлэх үзүүлэлт байдаг. Санхүүгийн зохицуулах

¹ Даатгалын үйл ажиллагааны ашиг дээр даатгалын бус орлогыг нэмсэн дүн.

хорооны зүгээс банк бус санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активд харьцуулсан харьцаа 30 хувиас доошгүй байна гэж заасан байдаг бөгөөд банк бус санхүүгийн салбарын хэмжээнд уг харьцааг ханган ажиллаж байгаа буюу өөрийн хөрөнгийн хэмжээ эрсдэлтэй хөрөнгийг бүрэн нөхөж чадахуйц байна.

Зураг 14. Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа: Банк бус санхүүгийн байгууллагууд нь олгосон зээлийг хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилах замаар зээлийн эрсдэлийн санг тооцож байгуулдаг. Санхүүгийн зохицуулах хороо зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг зээлийн ангилал тус бүр дээр тогтоож өгсөн байдаг. Тухайн банк бус санхүүгийн байгууллага байгуулбал зохих эрсдэлийн сангаа байгуулсан эсэхээс нь хамааран банк бус санхүүгийн байгууллага чанаргүй зээлээ нөхөх, эрсдэлээс хамгаалах чадвартай эсэхийг нь тодорхойлдог.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хувьд тайлант улиралд уг харьцаа 102.0 хувь гарсан буюу байгуулбал зохих эрсдэлийн санг бүрэн байгуулж чадсан бөгөөд эрсдэлийг 102.0 хувиар нөхөж чадамжтайг харуулж байна. Энэ өмнөх оны мөн улирлаас 5.9 нэгжээр илүү үзүүлэлт юм.

Зураг 15. Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант улиралд салбарын хэмжээнд 4.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан ба нийт 151.8 тэрбум төгрөгийн цэвэр зээлтэй байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.1 пунктээр буурч 4.1 хувьд хүрч нийт чанаргүй зээлийн хэмжээ 6.4 тэрбум төгрөгт хүрчээ. Харин салбарын нийт зээл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16.6 хувиар буюу 22.3 тэрбум төгрөгөөр өсөж 156.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Зураг 16. Нийт зээл ба чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Чанаргүй зээлийн ангилал дахь муу зээлийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 36.1 пунктээр өсөж 52.8 хувь болсон байна. Харин хэвийн бус зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь өнгөрсөн оноос 17.0 хувиар буурч 28.3 хувь болсон бол эргэлзээтэй зээлийн эзлэх хувь 19.1 пунктээр буурч 19.0 хувьд хүрсэн байна.

Зураг 17. Чанаргүй зээлийн чанарын үзүүлэлт /эзлэх хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хэвийн зээл өнгөрсөн оны мөн үеэс 19.3 хувиар буюу 23.5 тэрбум төгрөгөөр өсөж 145.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин нийт чанаргүй зээл өнгөрсөн оны тайлант үеэс 22.6 хувиар буюу 1.9 тэрбум төгрөгөөр буурч 6.4 тэрбум төгрөгт хүрчээ. Чанаргүй зээлийг бүрдүүлэгч хэвийн бус болон эргэлзээтэй зээл өмнөх оноос буусан бол муу зээл өнгөрсөн оноос 2.5 дахин өсөж 3.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


ЦАХИМ МӨНГӨНИЙ ТЭСРЭЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР

Цахим мөнгийг санхүүгийн үйлчилгээний салбарт гарсан хамгийн сонирхолтой, амжилттай, шинэлэг нээлтүүдийн нэг бөгөөд санхүүгийн хүртээмжийн асуудлыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн гэж үзсэн байдаг. Энэ бүтээгдэхүүн нь уламжлалт банкны үйлчилгээг хүртэх боломжгүй хүмүүст санхүүгийн үйлчилгээнд нэвтрэх шинэ арга замыг санал болгож буйгаараа онцлог юм.

Жишээ нь: Афганистан улсад цахим мөнгөний хэрэглээ улам бүр нэмэгдэж байна.

Хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээ авахдаа ердөө гар утастай байх мөн зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг орон нутгийн жижиг дэлгүүрүүдэд очих боломжтой байхад л хангалттай байдаг нь цахим мөнгөний хамгийн том давуу тал юм. Ингэснээр уламжлалт санхүүгийн үйлчилгээний байгууллагуудын хүрч чадахгүй, алслагдсан цэгүүдэд санхүүгийн үйлчилгээг хүргэх боломжтой юм. Афганистан улсад 1000 иргэдийн 200-гаас бага хүн нь банкны данстай бол улсын хүн амын 80-аас дээш хувь нь гар утастай байгаа нь цахим мөнгө амжилттай нэвтрэх ихээхэн боломжтойг харуулж байна. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэйгээр Афганистан улсын цахим мөнгөний хүртээмж аажмаар нэмэгдэж байна. Тус улсын хэмжээнд одоогийн байдлаар дунджаар 1000 км² тутамд нэг АТМ мөн 1 арилжааны банкны салбар байрлаж байхад цахим мөнгөний агент 3 байна. Сүүлийн таван жилийн хугацаанд цахим мөнгөний гүйлгээний хэмжээ дөрөв дахин өсч, 2018 онд Афганистан улсын ДНБ-ий 1.2 хувьд хүрсэн байна. Цахим мөнгөний үйлчилгээ нь зөвхөн төлбөр тооцоо хийх эсвэл P2P шилжүүлэг хийхэд ашиглагддаг төдийгүй засгийн газрын зардлыг төлөхөд (жишээлбэл, багш, цагдаагийн байгууллагын цалинг төлөхөд) мөн ашиглагдаж байна. Гэсэн хэдий ч тус улсын цахим мөнгөний хэрэглээний өсөлтийг хадгалах нь санхүүгийн болон мэдээллийн технологийн дэд бүтцээс нь хамаарна.

Зураг 18. Цахим мөнгө: Афганистан дахь санхүүгийн үйлчилгээнд хялбар нэвтрэх боломжийг бий болгосон байдал



Эх сурвалж: "Санхүүгийн хүртээмжийн түүвэр судалгаа", ОУВС, 2019 он

ЦАХИМ МӨНГӨ АШИГЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ ИДЭВХЖҮҮЛНЭ.

Улс орнуудын цахим мөнгөний зохицуулалтын орчныг үнэлэх зориулалт бүхий цахим мөнгөний зохицуулалтын индекс ашиглагдаж эхэллээ. Энэхүү индекс нь улс орнуудын зохицуулалтын орчныг илэрхийлдэг зургаан хэмжээсээс бүрдэх бөгөөд үүнд: тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийг таних, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зуучлагчдын сүлжээ, гүйлгээний дээд доод хязгаар, хөрөнгө оруулалт ба дэд бүтэц зэргийг илэрхийлэх үзүүлэлтүүд хамаарч байна. Индексийн өндөр утга нь илүү чөлөөтэй зохицуулалтын орчныг илэрхийлдэг.

БАГА, ДУНД ОРЛОГОТОЙ ОРНУУДЫН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИД ХҮЙСИЙН ЯЛГАА ГАРСААР БАЙНА.

Санхүүгийн хүртээмжийн судалгааны үр дүнгээс харахад бага, дунд орлоготой орнуудын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн санхүүгийн үйлчилгээний хэрэглээнд томоохон ялгаа байна. Пакистан, Уганда, Өмнөд Судан зэрэг оронд арилжааны банкуудын зээлдэгчдийн 30 хүрэхгүй хувь нь эмэгтэйчүүд байхад Европ, Дани, Польш зэрэг өндөр орлоготой орнуудын зээлдэгчдийн 50 орчим хувь нь эмэгтэйчүүд байна. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд зээлдэгчдийг хүйсээр ялгаварлахыг хориглосон хуультай улсуудын эмэгтэй зээлдэгчдийн хувь илүү өндөр байх хандлагатай байна.

ОУВС–ГИЙН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГААН ДАХЬ ХҮЙСИЙН МЭДЭЭЛЭЛ

2016, 2017 онуудад ОУВС санхүүгийн хүртээмжийн судалгаандаа хэрэглэгчдийн хүйсийн мэдээллийг оруулан цуглуулж эхэлсэн бөгөөд 2018 онд хүйсээр ангилсан хүртээмжийн үзүүлэлтийг түүвэр судалгааны бүлэг болгон оруулсан. 2019 оны Санхүүгийн хүртээмжийн судалгаагаар арилжааны банк, бичил зээлийн байгууллагуудын хэрэглэгчдийн хүйсийн тэнцвэртэй байдал харьцангуй сайн хангагдсан гэсэн үр дүн гарчээ.

2018 онд ОУВС–нд хүйсээр ангилсан хүртээмжийн үзүүлэлтүүдийг тайлагнадаг 35 улс байсан бол 2019 онд уг тоо нэмэгдэж 47–д хүрсэн бөгөөд Мексик, Румын, Зимбабве зэрэг шинэ улсууд нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Эмэгтэйчүүдийн зээл авах үйлчилгээ

Орлогын бүлэг	Улс	Эмэгтэй зээлдэгчийн хувь	Хуульд зээлдүүлэгчдээс зээл авахдаа хүйсээр нь ялгаварлан гадуурхахыг хориглодог.
Өндөр орлоготой	Дани	48	Тийм
	Польш	51	Тийм
Дунджаас өндөр орлоготой	Перу	47	Тийм
	Косово	31	Тийм
Дунджаас бага орлоготой	Пакистан	8	Үгүй
	Молдав	49	Тийм
Бага орлоготой	Өмнөд Судан	25	Үгүй
	Уганда	29	Үгүй


Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн судалгаа

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САНХҮҮЖИЛТ

ЖДҮ эрхлэгчид нь улс орнуудын орлогын дунджаар 40 хүртэл хувийг, ажлын байрны 70–95 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч зээл авах боломж нь хязгаарлагдмал байна. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон банкны зээл сүүлийн таван жилийн хугацаанд бага болон дунд орлоготой орнуудад ДНБ–ний 6 орчим хувьтай тэнцэж байна.

Харин 2019 оны санхүүгийн хүртээмжийн судалгаагаар жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн өсөлтөд томоохон өөрчлөлт гарсан нь харагдаж байгаа бөгөөд Гүрж, Фижи зэрэг улсуудад жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилт сайжирсан дүнтэй байна. Гүрж улсын ЖДҮ–ийн санхүүжилт сайжирсан нь тус улсын “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги 2016–2020”, болон ЖДҮ–ийг хөгжүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй үр дүнтэй, зорилтот бодлогын үр нөлөөтэй холбон тайлбарлаж байна. Харин Фижи улсад төв банк нь жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн баталгааны схемийн удирдамжийг үндэслэн ЖДҮ–ийн үндсэн зээлийн 50 хувийг төлөх баталгааг гаргасан нь ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Зураг 19. Арилжааны банкуудын ЖДҮ эрхлэгчдэд олгосон зээлийн үлдэгдэл (ДНБ–ий хувь)



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн судалгаа, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан

2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

10 ДУГААР САРЫН 31

Дэлхийн хуримтлалын өдөр

11 ДҮГЭЭР САРЫН 02

“Хөгжлийн төлөө хамтдаа” чуулган

11 ДҮГЭЭР САРЫН 14-15

26th annual conference of the International Association of Insurance Supervisors /IAIS/ , Abu Dhabi

11 ДҮГЭЭР САРЫН 04-07

Азийн санхүүгийн 3 дугаар форум

11 ДҮГЭЭР САРЫН 12

Сингапур финтекийн үзэсгэлэн яармаг

11 ДҮГЭЭР САРЫН 15

Эрдэм шинжилгээний хурал

МОНГОЛ УЛСАД САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАГДСАНЫ 25 ЖИЛ, ДААТГАЛЫН САЛБАРЫН 85 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН СУДЛААЧИД, ОЮУТНУУДЫН ДҮНД ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙН УРАЛДАНЫГ ЗАРЛАЖ БАЙНА.

ЗОРИЛГО Санхүү, бизнес, эдийн засгийн чиглэлийн судлаачид болон оюутнуудын бүтээн түүрвэх чадварыг дэмжиж, бүтээлийг нь нийгэд түгээн дэлгэрүүлж, санхүүгийн байгууллагын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд оршино.

Шилдэг бүтээлийн уралдаанд оролцсоор сонирхож буй судлаач, оюутан нийт 3 сэдвийн хүрээнд судалгааны бүтээлийг туурвина.

Бүтээлийн сэдэв: **Даатгал, Хөрөнгийн зах зээл, Бичил санхүүгийн зах зээлийг хамарна.**

СЭДВИЙН ЧИГЛЭЛ

- Санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, арга зам
- Санхүүгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх боломж, тулгамдаж буй асуудал
- Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын фоссал дааж чадвар, эрсдэлийг урьдчилан тооцох аргачлал

11 ДҮГЭЭР САРЫН 18

Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жил



12 ДУГААР САРЫН 10

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралдаан



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо